

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-49
1.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хянан шалгах түр хороо байгуулах тухай, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/	8-16
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/	16-18
3.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/	18-21
4.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	21-34
5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс хагас коксон шахмал түлшний асуудлаар Эрчим хүчний сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх	34-49

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
12 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Б.Заяабал;
Чөлөөтэй: Ч.Анар, О.Батнайрамдал, Д.Үүрийнтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа, Э.Одбаяр;
Тасалсан: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Б.Жавхлан, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн хэлэлцэх асуудлын дарааллын тавдугаар асуудал болох “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болгон хэлэлцэх горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	7
Бүгд:	17

58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хянан шалгах түр хороо байгуулах тухай, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Х.Шижирмөнх, Б.Уугантунгалаг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Тогтоолын төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг төсөл санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа танилцуулав.

Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Батчимэг, Б.Уянга нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж уншиж танилцуулав.

Р.Сэддорж: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨҮК-ийн Хөгжлийн албаны дарга Г.Галбадрах, мөн компанийн Техникийн бодлогын хэлтсийн дарга Г.Амартүвшин, Ерөнхий инженер П.Болдбаатар, ШУТИС-ийн профессор, Монгол Улсын зөвлөх инженер Д.Сүнжидмаа, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны эксперт Д.Галсанбуян, “Мөнхийн баянгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Бямбацогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Х.Шижирмөнх, Б.Уугантунгалаг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй байна.

Р.Сэддорж: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Х.Шижирмөнх, Б.Уугантунгалаг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Г.Очирбат нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний хэлтсийн дарга Д.Даваабаяр, Монголбанкны Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Х.Шижирмөнх, Б.Уугантунгалаг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Танилцуулга болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, П.Батчимэг, Г.Очирбат, С.Цэнгүүн нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Монголбанкны Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох.

11.1.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8
Бүгд:	19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс хагас коксон шахмал түлшний асуудлаар Эрчим хүчний сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Нийслэлийн засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдол хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Н.Наранбаатар, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаяр, мөн компанийн Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Ариунзаяа, Ерөнхий технологич Д.Өлзийбат, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын ерөнхий инженер Ч.Буянжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Х.Шижирмөнх, Б.Уугантунгалаг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Асуулгын хариуг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий танилцуулав.

Асуулгын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Ч.Лодойсамбуу, Г.Очирбат, С.Цэнгүүн, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Нийслэлийн засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдол хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс хагас коксон шахмал түлшний асуудлаар Эрчим хүчний сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 14 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 50 минут үргэлжилж, 31 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 64.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 16 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү, Ринчиндоржийн Батболд, Пүрэвийн Батчимэг, Жамбалын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Бадрахын Найдалаа, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал, Байнгын хорооны хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлц хэлэлцэнэ.

1.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 40 гишүүн 2025 оны 10 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн.

2.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл. Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сар 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

3.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс Эрчим хүчний сайдад тавьсан асуулгын хариу.

5.Байнгын хорооны тогтоолын төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоол.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу?

Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Би Эдийн засгийн байнгын хороогоор энэ улс орны яг төсөвтэй холбоотой, эдийн засагтай холбоотой гараад байгаа хүндрэлүүд дээр бид нэг анхаарлаа хандуулж, яг юу болоод байгааг нь сонсмоор байгаа юм. Төсвийн гүйцэтгэл маш их хэмжээгээр тасарсан. Тэгээд энийгээ нөхөхийн тулд аж ахуйн нэгжүүдийг хэт их хэмжээгээр дарамталж байгаа. Энийг бид холбогдох байгууллагуудыг нь дуудаж энийг сонсох хэрэгтэй байгаа юм. Том, жижиг гэхгүй бүх л аж ахуйн нэгжүүдийг. Зүгээр нэг дүүргийн төсөв гүйцэтгэлд саад учруулсан бол гэмт хэрэгт тооцно гэнэ үү. Тэрийг харж байгаа биз дээ? Тэгээд хэний буруугаас, юуны буруугаас болоод энэ төсвийн гүйцэтгэл энэ их хэмжээгээр тасарсан юм? Ийм хүмүүстээ хариуцлага тооцохгүй Их Хурал засна ч гэх шиг. Их Хурал яаж засах билээ? Гишүүдийн үгийг сонсож байхад Их Хурал засна гээд байх юм. Их Хурал засдаг тийм юм байхгүй л дээ энэ чинь. Төсвөө тодотгох юм уу, эс үгүй бол Засгийн газарт ямар нэгэн байдлаар энэ чинь хариуцлага ярих хэрэгтэй шүү дээ. Бид ямар гүйцэтгэх засаглал байгаа биш дээ энэ чинь. Бүгдээрээ ярьж байгаад засъя л гээд байх юм. Засах аргачлалыг нь би мэдэхгүй байна.

Тэгэхлээр энэ төсвийн гүйцэтгэлтэй, одоо та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ цалингаас өөр зардал гарахгүй. Тэгээд төсөв батлуулахдаа юу боллоо. Би тэгэхдээ 26 оны төсвийг яриагүй шүү. Энэ улаан, ногоон, цэнхрээр удирдаад байсан тэр төсвийг яриагүй. Би 25 оны төсвийг ярьж байгаа. Төсвийн алдагдалгүй гэж явж байгаад сүүлдээ энэ чинь хэдэн их наядын алдагдалтай билээ баталсан. Одоо тэрнээсээ бараг doubled-чихсан юм биш үү. Энийгээ Эдийн засгийн байнгын хороо сонсоод яг болоод байгаа нөхцөл байдлыг нь, тэгээд энэ жижиг аж ахуйн нэгжүүд рүү хэтэрхий их шахдаг, энийг далимдуулаад маш олон нугалаа үүсэж байна шүү дээ. Би яах вэ байхад нөгөө жижиг, дунд Байнгын хороон дарга нэлээн удсан. Тэгээд над руу хүмүүс зовлон жаргалаа ил тод бичиж байгаа юм. Тэгээд би хариулж чадахгүй юм л даа. Тэгэхээр энийг сонсож, энэ чинь хамгийн гол нөхцөл байдал болчихоод байна. Их Хурлын гишүүд тэгээд их олон зүйл рүү, аягүй олон зүйл рүү Их Хурлын гишүүд рүү их сатааруулж байгаа л даа Засгийн газар. Энэ чинь хамгийн гол нөхцөл байдал болчихоод байна. Энэ орлого талдаа анхаардаг байх хэрэгтэй.

Нүүрсээ зарж чадахаа больсон байна. Ингээд үг хэлэхлээр 2 хоног хэвлэлээр дайрдаг, аягүй бол цагийн дараа л нэг юм бичнэ. Юу гэх бол доо. Тэгээд бас нэг юмны хулгайд л нэг зургийг нь ороод хавчуулаад юу л болгох бол. Тэгэхлээр энэ байдал өөрөө хэтэрхий даамжирч байна. Жилд хэдэн удаа төсвөө тодотгодог болох вэ? Энэ чинь буруу тооцож байна шүү дээ. Чадахгүй байна тооцож. Ингээд дэлгэрэнгүй ярья гэхлээр минут хүрэхгүй.

Тэгэхлээр би нэлээн тийм үүсээд байгаа нөхцөл байдлыг нэлээн тийм товчоор хэллээ. Энийг Эдийн засгийн байнгын хороо нэлээн анхааралдаа авч сонсох хэрэгтэй байна. Сонсоно гэдэг нь энэ үүсээд байгаа нөхцөл байдлыг гүйцэтгэх засаглалын нөхдөөс сонсохоор хэрэгтэй байна. Энийг би хэлэлцэх асуудалд бас дараа дараагийн хэлэлцэх асуудалд Байнгын хороон даргыг оруулж өгөхийг бас хүсэж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүнд баярлалаа. Даргын дэргэдэх зөвлөл дээр энэ 7 хоногийн хэлэлцэх асуудалд Төсвийн байнгын хороо маргааш хэлэлцэх юм байна. Төсвийн байнгын хороо 2025 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлийг хэлэлцэнэ. Ингээд энэ 7 хоногийн даргын дэргэдэх зөвлөл дээр Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлыг ирэх 7 хоногийн Байнгын хорооны хурал дээр оруулах

саналыг манай Байнгын хорооноос оруулъя. Сангийн сайд, Монголбанк энд орж ирнэ. Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өглөөний мэнд хүргэе. Хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргах гэсэн юм. Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх 5-н асуудлын 5 дугаарт байгаа Байнгын хорооны тогтоолын төсөл буюу “Засгийн газарт чиглэл өгөх тухай” төсөл маань цахилгаан станцуудын үнсийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай асуудлыг 2 удаа хойшилсон байгаа. Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэх асуудлын 2 дугаарт оруулж өгнө үү гэж хүсье. Гишүүдээс санал хураалт авч өгнө үү.

Р.Сэддорж: Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулж гаргасан Цэнгүүн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

Өнөөдөр 5-н асуудал хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн хэлэлцэх асуудлын 5-д байгаа Байнгын хорооны тогтоолын төсөл “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 2-рт оруулж өгөөч гэсэн ийм санал гаргасан. Ингээд Цэнгүүн гишүүний гаргасан горимын саналаар энэ 2-рт оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Жудгийн Баярмаа танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье эрхэм Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн.

Энэ Хянан шалгах түр хороо байгуулах үндэслэл нь мэдээж Үндсэн хуульд заасан байгаа 6.1-д Монгол Улсын газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гээд. Мөн Үндсэн хуулийн 28.2 дахь хэсэгт хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал гаргах юм бол энэхүү түр хороог байгуулж ажиллуулна гэсэн байгаа.

Улмаар Харбины хэлэлцээр гэж нэрлэгдээд байгаа. Гурвыг цогцоор гэсэн энэ хэлэлцээртэй холбоотой байгуулагдсан холбогдох гэрээнүүд, байгуулах үеийн үйл ажиллагаа, бусад баримт бичгүүдэд шинжилгээ хийх, нотлох баримтын шинжилгээ хийх ийм зорилго бүхий ийм үйл ажиллагааг явуулах ийм түр хороод байгуулахаар санаачилга гаргасан байгаа.

Нийт Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс дээш буюу 40 гишүүн гарын үсэг зурсан байгаа юм. Энэ нэлээн удаан яригдсан учраас гишүүд мэдээлэлтэй байгаа гэж бодож байна. Ер нь 24 оны 12 сарын 27-нд Монгол Улсын

Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгуулсан аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүдийг л үзэж, шалгаж, түүнтэй холбоотой протокол, тэмдэглэлүүдэд экспертүүдийн шинжилгээ, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах ийм зорилготой байгаа юм.

Энэ дээр яригдаж байгаа нэг гол зүйл бол нүүрс худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ байгаа. Тэгэхээр энэ гэрээн дээрх үнийн асуудал нэлээн анхаарал татаж байгаа. Бид бүгдийн маш сайн мэдэж байгаагаар 9 сард чуулган эхлэхтэй зэрэгцээд багагүй тооны хүмүүс энэ асуудлаар шүгэл үлээж эхэлсэн. Үнэ хэтэрхий хямд байна. Урт хугацааны гэрээний хамгийн сүүлийн үнийн дүнг суурь болгоно оо гэсэн ийм заалтыг хэлэлцээрт оруулсан нь хэтэрхий багаар тогтоосон байна. Тэр хамгийн сүүлийн гэрээ өөрөө бараг 50 орчим доллароор тогтоогдсон ийм Чалкогийн гэрээ байгаа. Тэгэхээр суурь үнийг 50 доллар гэж авсан бол энэ ерөөсөө орчин үед байж болохгүй ийм бага үнийн дүн юм гэдэг асуудлаар шүгэл үлээж Улсын Их Хурлын гишүүдэд хандсан байгаа юм.

Тэгэхээр энэ гэрээний суурь болсон хэлэлцээр Улсын Их Хурлаар батлагдсан, соёрхон батлагдсан байгаа юм. Тэгэхээр энэ хэлэлцээрийг Эдийн засгийн байнгын хороо маш сайн авч хэлэлцсэн байдаг. Тэн дээр асуудлыг гишүүд нэлээн нухацтай асуусан байдаг. Тэгэхээр та бүхэн энэ талаар маш сайн мэдээлэлтэй байгаа гэж бодож байна. Ялангуяа Энхтүвшин гишүүн, миний уншсанаар Батсүмбэрэл гишүүн нар энэ Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцэж байгаа гэрээ мөн үү, энэ гэрээний чинь ард дахиад хулгай явах гэж байгаа юм биш байгаа гэх мэтийн маш тийм ноцтой асуултуудыг тавьсан байсныг та бүхэн санаж байгаа байх.

Тэгэхээр энэ үнийн дүн ер нь яг хэдээр тогтоогдсон юм бэ гэдгийг бид нар ерөнхийдөө мэдэхгүй байгаад байгаа. Яагаад гэвэл тэр гэрээ нь тодорхой хэмжээнд нууцлагдсан байгаа. Сүүлд Засгийн газраас тогтоол гаргаж нууцын буюу оффтейкийн гэрээнүүдийг ил болгосон боловчиг яг энэ Харбины хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн энэ гэрээ ил болоогүй байгаа. Ялангуяа энэтэй холбоотой материал, протокол, тэмдэглэлүүд ерөөсөө ил болоогүй байгаа юм. Тэгэхээр яг энэ иргэдийн хардаад байгаачлан энэ нүүрсний үнийг маш багаар тогтоосон нь үнэн эсэхийг хянаж шалгах шаардлагатай байгаа.

2 дугаарт бас нэг асуудал яригдаж байгаа. Сорчилж болохгүй гээд. Өөрөөр хэлбэл, коксожсон нүүрсийг илүү их хувийг олгох буюу нийлүүлэх боломжгүй бөгөөд ингэх ёсгүй гэсэн ийм шаардлагыг бас гишүүд тавьж байсан юм байна лээ. Ялангуяа манай Золжаргал гишүүн энэ тогтоолын төсөлд, хэлэлцээрийн төсөлд зориуд энэ сорчлохгүй байх гэсэн заалт оруулсан байдаг. Гэхдээ яг бодит амьдрал дээр энэ нь ер нь яг гэрээн дээр юу гээд тусгагдчихав 55 хувийг нь коксожсон нүүрс нийлүүлнэ гээд тусгачихсан байгаа гээд байгаа.

Гэтэл энэ нь явсаар байгаад Монгол Улсын нийт Эрдэнэс Тавантолгойн нүүрсний нөөцийг 6 тэрбум тонн гэж үздэг бол коксожсон нүүрс нь 10 хувь нь гээд 600 сая тонн гэж үзэх юм бол нийт энэ 250 сая тонн нүүрс нийлүүлэх гээд байгаагийн 55 хувь гэж үзэх юм бол 100 гаруй тонн, 130-аад сая тонн нь коксожсон нүүрс явах нь. Тэгэхээр нөгөө нийт 600 сая тонны бараг 150 орчим нь ингээд

коксожсон нүүрс болоод энэхүү гэрээний дагуу явах нь гэсэн ийм хардалтууд маш их байгаа. Тэгэхээр энэ гэрээтэй танилцах шаардлагатай байгаа.

Ер нь эцсийн зорилго бол энэ гэрээний тэр үнийн дүнтэй танилцаад бас нэг ноцтой зүйл яригдаад байгааг та бүхэн санаж байгаа байх 2024 оны 2 сард Эрдэнэс Тавантолгойн БЭТ Ганбат гэдэг хүнээс тухайн үеийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга руу яг энэ Харбинтай холбоотой энэ хийгдсэн гэрээ, хэлэлцээрийн явцын талаар тайлан тавьсан байдаг. Тэр тайлан дотор юу гэж байдаг вэ гэвэл ерөнхийдөө БНХАУ-ын “Чайна Энержи” компани бол нүүрсийг цаашид тухайн үеийн биржийн үнээр авахад бэлэн гэдгээ хүлээн зөвшөөрлөө гэдэг заалт байдаг. Хамгийн гол заалт. Биржийн үнээр авахыг хүлээн зөвшөөрсөн.

Гэхдээ 5 хувийн хөнгөлөлт үзүүлээч гэсэн саналыг манай талд тавьж байгаа гэсэн ийм заалт орсон байдаг. Тэгэхээр хэрвээ энэ биржийн үнээр худалдан авахыг зөвшөөрсөн бол яагаад, ямар шатдаа, хэн, яаж энэ биржийн үнээр худалдан авахыг нь болиулж, тогтвортой нэг үнэ болгов. Тэгээд тэр нь 50-60 долларын хооронд хэлбэлзэхээр болов оо гэдэг асуудлыг л ерөнхийдөө шалгаж, судалж нягтлах юм байгаа юм.

Эцсийн дүндээ хэрвээ энэ гэрээний үнэ үнэхээрийн ашигтай, Монгол Улсын эдийн засагт үр нөлөөтэй, нийтийн ашиг сонирхлыг хангасан ийм үнийн дүн байх юм бол энийг сайшаагаад, алгаа ташаад энэ гэрээг байгуулсан гарын үсэг зурсан хүмүүсийг одоо яах юм мандуулах ёстой гэж бодож байгаа би хувьдаа. Хэрвээ энэ гэрээний үнийн дүн нь асуудалтай арай өөрөөр буюу илүүгээр тогтоож болох байсан сан бол энийг ярилцсаны үр дүнд дүгнэлт, мэдээж шинжээч, экспертүүд ажиллаж таарна. Энэ шинжээч, экспертүүдийн гаргасан дүгнэлтэд үндэслэж, Засгийн газарт санал тавина. Өөрөөр хэлбэл, Засгийн газарт энэ гэрээгээ өөрчлөх, засаж сайжруулах шаардлагыг тавих ийм л үндсэн зорилготой.

Тэгэхээр энэ зорилгын хүрээнд энэ түр хороо ажиллах юм байгаа юм. Тэгээд яах вэ дахиад давтан хэлэхэд эцсийн зорилго нь бол энд хэн нэгнийг буруутан болгож тогтоохоосоо илүү энэ гэрээг сайжруулах зорилготой байгаа. Үнийн дүнг нь нэмэгдүүлэх. Хэрвээ тийм боломж байгаа бол. Тэгээд Засгийн газар энийг бас хүлээн зөвшөөрнө гэж бодож байгаа.

Энэ гэрээг байгуулсан тухайн үеийн Ерөнхий сайд хүртэл өөрөө хэрвээ онцгүй, муу гэрээ болсон гэж үзэж байгаа сайжруулах боломж нь байгаа шүү дээ гэж дуугарч байсан. Тэгэхээр нэг талаасаа ер нь жоохон тааруу гэрээ болсон байхыг хүлээн зөвшөөрч байгаа мэт. Нөгөө талдаа сайжруулах боломж байгаа гэж хэлсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр түр хороо бол эцсийн зорилго нь энэ гэрээний үнийн дүнг экспертүүдээр дүгнүүлээд тэгээд нэмүүлэх энэ боломжийг л хайх юм байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн түр хороо байгуулах асуудлыг дэмжиж өгнө гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Улсын Их Хурлын гишүүн Батчимэгээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Түр хороо байгуулах саналыг дэмжиж гарын үсэг зурсан. Ер нь бас хүмүүст бас ойлгомжтой байлгах үүднээс ялангуяа өмнө нь Оюун-

Эрдэнэ нарын 37 гишүүнээс барьсан энэ Ухаа худагтай холбоотой гээд Хянан шалгах түр хорооноос одоогийн байгуулах гэж байгаа түр хороо маань юугаараа ялгаатай байх юм бэ гэдэг талаар нэг тайлбар өгөөч.

Р.Сэддорж: Баярмаа гишүүн хариулъя.

Ж.Баярмаа: Юугаараа ялгаатай юм бэ гэвэл Оюун-Эрдэнэ гишүүн нарын түр хорооны зорилго бол урьд өмнө сүүлийн хэдэн жилийг хамарсныг нь би мэдэхгүй байгуулагдсан оффтейк гэрээнүүдийг шалгах, хянан шалгах гэсэн ийм зорилготой байсан. Энэ гэрээнүүд дотор эсвэл энэ гэрээнүүдээс гадна ч юм уу Ухаа худгийн гэрээг хэрхэн, яаж байгуулсан тухай хяналт шалгалт оруулах гэсэн ийм зорилготой байсан.

Өөрөөр хэлбэл, цаг хугацааны хувьд мэдээж өөр, өнгөрсөн оффтейк гэрээнүүдэд, дээрээс нь Оюун-Эрдэнэ гишүүн өөрөө Ерөнхий сайд буюу кабинетаа толгойлж байхдаа байгуулсан өөрийнхөө оффтейк гэрээнүүдийг шалгах тэр түр хороо байгуулна гэдэг нь өөрөө ашиг сонирхлын зөрчилтэй. Угаасаа Хяналт шалгалтын тухай хуулиараа бараг бүрэлдэхүүнд нь орохыг хүртэл хориглож байгаа. Энэ Ухаа худаг буюу энэ оффтейк гэрээнүүдийг шалгах түр хороо байгуулах бүрэн боломжтой гэж би үзэж байгаа.

Гэхдээ түр хороог байгуулах тэр санаачилгыг буюу ахлах хүн нь өөрөө энэ оффтейк гэрээнүүдийг байгуулсан байх боломжгүй. Ёс суртахууны хувьд ч тэр, хууль зүйн хувьд ч тэр тэрүүгээрээ.

2 дугаарт, энэ Харбины хэлэлцээртэй холбоотой гэрээ бол зөвхөн Харбины хэлэлцээрийн дагуу байгуулагдсан нүүрс худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ. Ерөөсөө сүүлийн үеийн нэн шинэ гэрээ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, сая 25 оны 3 сард байгуулагдсан гэрээ. Тэгэхээр бид нар өмнө буруу, зөрүү янз бүрийн гэрээ байгуулаад хэдэн жилийн дараа тэрнийхээ араас хөөцөлддөг бус яг тухайн үед нь хэрвээ буруу, зөрүү байгуулсан байх аваас засаж сайжруулах энэ ажлыг нэн яаралтай хийх нь чухал байгаа юм гэж үзэж байгаа юм. Тэр утгаараа яаралтай энэ түр хороог байгуулж, хянан шалгаж, энэ гэрээг засаж сайжруулах шаардлагатай буюу өөрөөр хэлбэл, нүүрсний үнийг нэмэх, эсвэл биржийн үнээр худалдах энэ чиглэл рүү нь оруулах боломжийг эрэлхийлж байгаагаараа ялгаатай юм.

Өөрөөр хэлбэл, нэг л гэрээний тухай асуудал яригдаж байгаа. Өмнөх асар олон буюу өнгөрсөн оффтейк гэрээнүүд ийм ялгаатай юм.

Р.Сэддорж: Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг.

П.Батчимэг: Баярмаа гишүүн, Ганбат гишүүн нарын санаачилсан энэ Хянан шалгах түр хороо байгуулах тухай юунд гарын үсгээ зурсан, дэмжиж гарын үсгээ зурсан. Энэ Харбины нүүрсний гэрээ, энэ асуудал маш их асуудал дагуулж, эргэлзээ төрүүлж, энийг зайлшгүй энэ гэрээг ил гаргаж шалгах ийм зорилго бүхий түр хороо байгуулагдаж байгаа нь үнэхээр сайшаалтай. Тэгээд Баярмаа гишүүнийг энэ түр хороог ахалж үнэхээрийн тэр улс орны эрх ашиг, ард түмний эрх ашиг, энэ нүүрсний тэр үнэ, тэгээд түрүүний ярьсан тэр ялгавартай байдлаар тогтоох энэ асуудлыг энд бүүр ингээд ангилчихсан байгаа шүү дээ. Коксжих, сул коксжих эрчим хүчний нүүрс гээд. Тэгэхээр энэ нь үнэхээрийн яг энэ гэрээний дагуу явагдаж чадсан уу үгүй юү? Тэр бас нүүрсний хэмжээ, нийлүүлэх нүүрсний хэмжээ яг гэрээний дагуу нийлүүлэгдэж байгаа юу үгүй юү? Өнөөдрийг хүртэл нүүрсний

энэ нүүрс маш муу юу яаж байна гэж яриад байгаа тийм ээ. Тэгэхээр энэ асуудал дээр энэ гэрээг ил гаргаад үнэхээр шударгаар ажиллаж, энийг гаргаж ирж чаддаг бол, буруу, зөвийг гаргаж ирж чаддаг бол үнэхээр сайн ажил болно оо гэж харж байгаа юм.

Тэгэхээр энд байгаа нэг энэ гэрээ байгуулах хүртэл олон удаа уулзалт, хэлэлцээр хийж, тэгээд талуудын байгуулсан гэрээ, олон удаагийн уулзалт, хэлэлцээрээр ярилцаж тохиролцсоноос өөр нөхцөлөөр гэдэг нь Баярмаа гишүүний түр хороо, Хянан шалгах түр хороо байгуулагдах үндэслэл болсон гэж үзэж болох уу? Яг энэ дээр ямар асуудлыг бүүр тодотгоод байгаа юм бэ гэдгээ дахиад нэг сайн тайлбарлаад өгөөч. Одоо экспортын орлого тасраад байна л гэж байгаа шүү дээ. Нүүрсний борлуулалт тасраад байна. Одоо нийлүүлэх яг бодит хэмжээндээ хүрэхгүй байгаа нь үнэхээр ил мэдрэгдэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр та дахиад нэг тодруулаад хэлээд өгөөч.

Р.Сэддорж: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Маш чухал асуултыг хөндлөө. Яг үнэн. Удаа дараагийн хэлэлцээрийн үр дүнд дараах асуудал дээр тохиров гэсэн агуулга бүхий танилцуулгыг 2024 оны 2 сард Эрдэнэс Тавантолгойн БЭТ Ганбат бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байсан тухайн үеийн Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүнд бичгээр хандсан байдаг юм. Тэр дотор би түрүүн хэлсэнчлэн айлын тал нүүрсийг биржийн үнээр авахыг зөвшөөрөв гэдэг ийм өгүүлбэр байгаад байгаа юм.

Гэхдээ мэдээж энэ чинь урт хугацаанд хийгдэх гэрээ учраас айлын талаас бас тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэхийг хүсэх нь бас тодорхой. Энэ чинь бизнесийн асуудал. Тэгээд 5 хувийн хөнгөлөлт үзүүлнэ үү гэсэн хүсэлтийг тавьж байгаа гээд. 7 удаагийн хэлэлцээрийн ар дээр дараах зүйлс яригдав гэсэн байгаа юм. Маш тодорхой биччихсэн. Тэгээд 24 оны 2 сараас хойш яг 1 жилийн дотор ямар уулзалтууд, ямар хэлэлцээнүүд явсны үр дүнд нөгөө айлын талын зөвшөөрсөн тэр биржийн үнээр худалдан авах энэ нөхцөл нь өөрчлөгдөөд тогтмол буюу бид нарын хардаад хүмүүсийн яриад байгаа 50-60 долларын хооронд болчхов оо гэдгийг л бид нар хянан шалгах гээд байгаа.

Магадгүй тэр 7 удаагийн хэлэлцээрийн дагуу тохирсон ёсоор биржийн үнээр худалдахыг гэрээндээ тусгачихсан байсан бол тэр нь жишээлбэл өнөөдөр биржийн үнэ 120 доллар гэж байвал тэндээс 5 хувийн хөнгөлөлтийг хасахад 6 доллар хасаад нийт 114 доллароор 1 тонн нүүрс маань зарагдах бүрэн боломжтой байсан байна гэж ерөнхийд нь үзээд байгаа. Нарийн тэр гэрээтэй, тэр хэлэлцээрүүдтэй танилцаагүй учраас нарийн мэдэхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ чинь эцэстээ хэрвээ 50 долларын зөрүү, 40 долларын зөрүү байна гэж үзэх юм бол нөгөө хүмүүсийн яриад байгаа 10 тэрбум доллар буюу нийт бараг 36 их наяд төгрөг буюу манай Монгол Улсын жилийн төсвөөс давсан ийм орлогыг бид алдах гэж байгаа юм биш үү гэдэг л эрсдэл байгаад байгаа юм.

Гэхдээ хамгийн гол зорилго бол эдгээр гэрээний заалтуудтай маш нарийн танилцах хэрэгтэй. Тэр тооцооллыг нь судлах хэрэгтэй. Тэгээд та бүхэн санаж байгаа бол анх Улсын Их Хурал дээр хэлэлцээр орж ирж байхад Улсын Их Хурлын гишүүд маш их асуусан. Яг энэ үнээ яаж бодоод байгаа юм бэ, ямар схемээр яаж тогтоод байгаа юм бэ гэдгийг асуусан боловч яг тоймтой хариу авч чадаагүй. Үнэхээр авч чадаагүй. Би өөрөө хүртэл асуугаад яг ингээд ингээд, ингээд ийм

доллар болох юм гэдэг үнийн дүнг сонсоогүй. Та бүхэн ч сонсоогүй байх гэж бодож байгаа.

Тэгэхээр яагаад ийм үнийн дүнгээр гэрээ хийчхэв, өөр боломж байгаагүй юм уу гэдгийг л судлах юм. Байгаагүй бол нэг хэрэг. Байсан бол бас нэг хэрэг. Цаашид сайжруулж болох эсэх энэ рүү л чиглэх юм байгаа юм. 10 доллароор ч болтугай нэмэхэд Монгол Улсад төдий чинээ тэгээд бараг 10-аад их наядын орлого орж ирэх жишээний. Тэгэхээр энэ их мөнгө бол өнөөдөр нөгөө цалин хөлсөө төлж чадахгүй байгаа эмч, багш нар гээд л өдөр болгон хэрүүл хийж байна. Одоо орлого тасарлаа гээд дөнгөж сая бид нар ярилаа, ярьж байна тээ. Тэгэхээр цаашид урт хугацаанд бид нар тогтвортойгоор, биржийн үнээр гэхдээ мэдээж айлын талд хөнгөлөлт үзүүлсэн ийм нөхцөлийг дахиж тохирч чадах юм бол маш сайн. Эс бөгөөс ядаж тэр тохирсон тэр 60 юм уу 50 доллар дээр нь тодорхой хэмжээний үнийн дүнг нэмэх энэ рүү л зорих юм байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Өчигдөр, одоо бол Оюу толгой дээр сонсгол явж байгаа тээ. Тэгээд өчигдөр яг ажилдаа ирээд байж байсан чинь нэг танил эгч маань залгалаа л даа. Уул уурхайтай ерөөсөө холбоотой хүн биш. Тэгээд ингээд ярьж байснаа тэгээд л дахиад л нүүрс гээд л бөөн юм ярих нь дээ гээд л тэглээ. Тэгэхээр нь юун Оюу толгой шүү дээ. Оюутолгой чинь зэсийн орд шүү дээ гэхээр мэдэхгүй мэдэхгүй гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр нэг тийм ард иргэд нэг их тийм Оюун толгойн нүүрс юм уу, зэс юм уу, яадаг юм ийдэг юм гэдэг нэг их тийм энгийн өдөр тутмын амьдралд нэг их тийм хамаатай биш байтал энэ Хянан шалгах түр хороо гэж байгуулагдаад л ингээд л төсөл төслөөр нь татаж гаргаж ирээд л яриад л ерөнхий мессеж нь бүгд л улс төржөөд л уул уурхайн салбар болохгүй байгаа юм байна, хар байгаа юм байна л гэсэн мэдээлэл өгч байгаа юм. Тэгээд энэ нь л илүү даамжрах юм шиг санагдаад байх юм.

Сая Баярмаа гишүүнийг хүн хэлж, ярьж байгаа зүйлийг нь хүмүүс энгийн иргэд нэлээн сайн сонсдог гэж би боддог. Сая ингээд танилцуулж байгаа танилцуулга дээр хүртэл энэ гэрээний үнэ 1 тонн 50 доллар, нүүрс нь 50 доллароор үнэлэгдсэн байна гээд ингээд дурдчихаж байгаа юм. Тэгтэл яг ингээд нарийн ингээд яг салбарын мэргэжилтэн хүний хувиар бодохоор яг ямар төрлийн нүүрсний биржийн үнээр гэж зөвшөөрсөн байсан юм гээд байгаа юм. Биржийн үнэ чинь байнга хөдөлж байдаг юм шүү дээ. Өнөөдөр яг энэ эрдэс баялгийн энэ эдийн засаг, энэ “mining economy” талдаа ашигт малтмалын үнийг ерөөсөө ирээдүйг нь “forecast” хийж чаддаггүй байхгүй юу. Ямар ч модель хийж чадахгүй байгаа байхгүй юу.

Тэгэхэд олон жилээр хийгдсэн гэрээг барьж аваад л бүүр нэг нэг төсөл гэдэг байсан бол боомт дээр хийж байгаа гэрээг барьж авч ярих юм байна л даа. Би энийг улс төржилт гэж харсан учраас дэмжиж гарын үсэг зураагүй. Мэдээж энэ хүртэл ингээд явж байна. Гишүүд тэгээд өөрсдөө шийдэх байлгүй. Миний хэлэх гээд байгаа юм нь санал юм уу даа. Яах вэ энэ Хянан шалгах түр хороо байгуулж болох юм.

Тэгэхдээ хүн болгонд хэрэгтэй зүйлийг нь ярьдаг болчихвол. Эрүүл мэндийн даатгалын санг яримаар байна шүү дээ. Нийгмийн даатгалын санг яримаар байна. Хүүхдийнхээ цэцэрлэгийн талаар би яримаар байна. Маш олон эцэг, эхчүүд энийг сонсмоор байгаа. Тэгтэл ингээд нэг тийм бараг л Оюу толгой, Тавантолгойгоо

ялгахгүй байгаа иргэдэд нэг тийм нүүрс 50 доллар гэдэг ойлголт л өгөх гээд байгаа юм шиг байгаа. Тэгэхээр цааш цаашдаа анхаараад хянан шалгах түр хороог санаачилж байгаа бол нийт иргэдийнхээ масст хамааруулж ярих нь зүйтэй л гэж бодож байгаа даа. Санал гэж хэлэх юм уу миний хувьд ерөөсөө дэмжихгүй байгаа.

Р.Сэддорж: Баярмаа гишүүн хариулна.

Ж.Баярмаа: Уянгаа гишүүнтэй санал бас тодорхой хэмжээнд нийлж байгаа. Хамгийн гол нь асуудлыг улс төржүүлэхдээ гол биш. Яг Монгол Улсад эцсийн дүндээ ямар нэгэн үр дүн бий болгох эсэх тухай л асуудал яригдаж байгаа.

2 дугаарт, түр хороог байгуулах эрх Улсын Их Хурлын гишүүдэд байгаа ямар ч асуудлаар. Тэр улс эх орны эрх ашигт хамааралтай гэж үзэж байгаа асуудал болгоноор хянан шалгах түр хороо байгуулах бүрэн эрхтэй гэж үзэж байгаа. Тэгэхээр эрүүл мэндийн даатгалын тогтолцоо мэдээж чухал. Энэний ард байгаа тэр бас л маафан шүү дээ. Яагаад шалгах гээд байна гэвэл ард нь янз бүрийн хулгай зэлгий явчих вий гэдэг үүднээс л сэргийлээд байгаа юм л даа. Өмнө нь явчихсан ийм түүхүүд байна, туршлагауд байна. Баахан оффтейк гэрээнүүд байгуулаад хулгай хийчихсэн гээд. Асар олон хүмүүсийн нүүрсний хэрэгтэй холбогдчихоод эхнээсээ дарга, цэрэггүй сууж байна л даа. Энэ бодит баримт факт. Тэгэхээр тэгээд өмнөх туршлагаасаа бид нар суралцаж дахиж хэн нэгнийг нүүрсний хэрэгтэй холбуулахгүйн тулд эхнээсээ энэ гэрээгээ зөв, шударгаар ард түмний тусын тулд хийгээд явчих юм бол дараа хэн нэгнийгээ дахиад ингээд шүүгээд хэрэгт холбогдуулаад ингээд сууж байхгүйн төлөө хийгдэж байгаа юм.

Тэгэхээр нүүрс маш чухал бүтээгдэхүүн. Монгол Улсын экспортын дийлэнх олонх хувийг эзэлдэг. Тэгэхээр энэ бол ард түмэнд асар их хамааралтай, маш их хамааралтай. Үүгээрээ Монгол Улс тэжээгдэж байна, орлого олж байна. Тэгэхээр энийг иргэд сонирхох ёстой. Тэр утгаараа энэ түр хороог байгуулж энэ үнийг буруу, зөрүү хийсэн эсэхийг л шалгах гэж байгаа юм л даа. Хэрвээ зөв хийгээд ямар ч асуудалгүй байх юм бол би түрүүн хэлсэн шүү дээ сайшаан магтъя гэж байгаа шүү дээ. Иргэддээ гол нь мэдээлэл өгмөөр байгаа юм. Иргэдээс ингээд нуучхаад байна л даа. Дандаа л жилийн жилд нэг гэрээ байгуулаад л оффтейк болгоод л нууцын тамга дарчихдаг. Тэгээд ар дээр нь юу илэрдэг вэ гэвэл хулгай зэлгий илэрдэг. Нүүрсний хулгай гээд. Уянгаа гишүүн маань сая хэллээ л дээ зэсийн асуудал ярьж байхад нөгөө л нэг нүүрс хийдэг болтлоо нүүрс чинь өөрөө хулгай дагуулсан байна. Тэгэхээр дахиж хулгай гаргахгүйн тулд яаралтай энэ түр хороог ажиллуулж эртхэн тэр гэрээг нь засварлах ийм л зорилготой байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Уянгаа гишүүн тодруулж асууна.

Б.Уянга: Улс төржилт хэрвээ биш бол ийм гаргалгаа байсан. Эдийн засгийн байнгын хороон дээр яг тэр гэрээг татаж авчирч байгаад харах боломж байсан. Их Хурал дээр гишүүдэд ерөнхий хэлэлцээр нь орж ирсэн. Гэрээг засаг дээр хийсэн. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороон дээр хараад үнийн дүнг нь шинжлээд тогтоол, Байнгын хорооны тогтоолыг гаргаад засаг руу өгөөд, засгийг ажлаа хийхийг нь шаардах ийм гаргалгаа байсаар байтал ингэж дээд түвшнийг авхуулаад ерөнхий дүр зураг нь нэг хүмүүсийг хардаж, шүүхээр тогтоогоогүй байхад нь хулгайч гэж нэр зүүлгэх энэ ерөөсөө байж боломгүй асуудал. Хэн, хаана хүнийг буруутайг нотолдог юм бэ гэдгээ хүртэл манайхан ойлгохгүй болтол нь төөрөгдүүлж байгаа. Энэ том асуудал гэж харж байгаа. Тэгээд цааш цаашдаа энэ

бусад бүгдэд хамаатай асуудлаар хэрвээ түр хороо хянан шалгах асуудал бий болбол тэр дээр л хийх ёстой гэж бодож байна.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Түр хорооны бүрэлдэхүүний талаарх тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Хянан шалгах түр хороо байгуулах тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгуулсан гэрээ хэлэлцээр, түүний бэлтгэл ажил, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээ, баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог байгуулсугай.

2.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Олонхыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир, Улсын Их Хурлын гишүүн Жангабыл, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн, цөөнхийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Баярмаа, Улсын Их Хурлын гишүүн Ганбат, Улсын Их Хурлын гишүүн Батболд, Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Улсын Их Хурлын гишүүн Энхнасан.

3.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай.

1.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгуулсан хоёр улсын гэрээ хэлэлцээр, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээ, холбогдох бусад баримт бичиг, үйл ажиллагаа.

2.Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоол батлахаас өмнөх жилүүдэд хийсэн хоёр улсын Засгийн газар, ажлын хэсэг, аж ахуйн нэгж хоорондын уулзалт, хэлэлцээртэй бүх баримт бичиг.

4.Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь

хэсэгт заасан хугацаанд Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2025 оны батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. Томьёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

12.01 цаг

Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэх асуудал 2.Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаар мэдээлэл сонссонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооноос хорооны тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд тараасан.

Энэ тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Алга байна.

Тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Засгийн газарт чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зарим зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2-т заасан дулааны цахилгаан станцуудыг шинээр барих, эрчим хүчиний чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх үйл ажиллагааг судлан шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

2.Дулааны цахилгаан станцуудын ашиглалтын үйл явцад үүссэн хаягдал үнс нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, цаашид инновац шингэсэн шинэ технологи ашиглан хаягдал үнсийг эдийн засгийн эргэлтэд оруулж, зам, барилгын болон бусад салбарт ашиглаж болох түүхий эд, бүтээгдэхүүн бий болгох талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.Нүүрсний тоосонцроос үүсэх орчны бохирдлыг бууруулах зорилгоор орчны мониторинг тогтмол хийж, нүүрс хадгалах ил талбайг хаалттай байгууламжид шилжүүлэх, мананжуулах системийг ашиглан ачилт, тээвэрлэлтийн үеийн тоосжилтыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд, авто болон төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтад, хөрсний сайжруулалт зэрэг чиглэлд ашиглах аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх талаар судалж, саналыг боловсруулж, хэрэгжилтийг хангах.

5.Хаягдал үнс боловсруулах технологид тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийн импортын тоног төхөөрөмжид гаалийн татварын хөнгөлөлт, санхүүгийн болон бодлогын дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулж хэрэгжүүлэх.

6.Хаягдал үнсийг ашиглан цемент, бетон, барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдийн түүхий эд нийлүүлэлтийг урт хугацаагаар тогтворжуулах, үнсний хангалтын гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

2.Энэ тогтоолын биелэлтийг 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтааж Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

Ийм тогтоол байна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалтын томъёоллыг танилцуулъя.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

12.06 цаг

Хэлэлцэх асуудлын 3-д байгаа Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл.

Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэгдэж байгаа учраас дараагийн асуудлыг хэлэлцэж байя.

Дараагийн асуудал.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний талаар” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар” Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлах нь зүйтэй гэсэн санал дэмжигдсэнтэй холбогдуулан ажлын хэсгээс дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсныг Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Ганбаатар гишүүнээр тасалъя. Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Бид ер нь аливаа асуудалд хандахдаа энэ орлогыг их зөв төлөвлөх, би энийг бараг гишүүн болсноосоо хойш хэлж байгаа юм л даа орлогоо их зөв төлөвлөх хэрэгтэй. Энэ цамаан байдлаа засах хэрэгтэй. Төрийг их цомхон болгох хэрэгтэй. Тэгээд энэ 3 зүйл ер нь маш чухал даа. Ямар ч төлөвлөгөө баталсан, ямар ч хөгжлийн загвар боловсруулсан ер нь бид бол Монгол Улсад боломж байгаа. Монгол Улс мөнгөтэй улс, баялагтай улс.

Тэгээд энийг ер нь тэгэхдээ нэг ийм юм удирдаж авч явж байгаа хүмүүс бол ер нь чадахгүй юм байна лээ л дээ. Тэгээд би өөрийгөө их дөвийлгөж ярьж байгаа

юм биш. Ер нь мөнгөтэй юм уу ер нь бизнес, аж ахуйтай харьцаж үзсэн хүний нүдээр харж энэ улс орны хөгжлийг харахгүй бол ер нь дан ганц зүгээр сайхан сэтгэлээр энэ асуудал бүтэхгүй л дээ. Ер нь санхүү, мөнгөтэй холбоотой асуудал дээр Оюун-Эрдэнийн Засгийн газар маш том алдаа гаргасан. Энийг би байнга хэлж залруулж байсан. Зөндөө л ад болж байсан. Одоо энэ Занданшатарын Засгийн газар энийг давтахгүй байх хэрэгтэй.

Цаашдаа Монгол Улс энэ орлого талаа маш зөв төлөвлөдөг, худлаа хийсвэр, чадахгүй байдлаар төлөвлөөд өнөөдрийн байдал үүсэж байгаа шүү дээ. Өнөөдөр нүүрс гэхэд нүүрсний орлого 3 их тэрбум доллароор тасарсан байна шүү дээ. Биет хэмжээ нь яах вэ нэг юм яваад байдаг тэгээд мөнгө байхгүй. Зэс чинь ер нь тэгээд Оюу толгойн зэс зүгээр л тоо юу шүү дээ. Зүгээр л эдийн засгийн үзүүлэлт, орлого гэж байхгүй. АМНАТ нь 5-хан хувь. Тэгээд энд сонсгол хийж байгаа хүмүүс мэдэж байгаа байлгүй дээ тэрийг.

Тэчнээн сая тонн зэс гарлаа, тэдэн тонн алт гарлаа л гэдэг тэр бол Монголд ер нь нэг их хамааралтай биш. Тэр орлого гэж байхгүй. Энийг нөхдөг гол зүйл бол нүүрс байна. Тэгэхдээ нүүрсээ бид яг өнөөдрийн байдлаар бид нүүрсээ олигтой үнээр зарж чадахгүй. Тэгээд янз янзаар тайлбарладаг. Арчаагүй байна л даа. Аливаа зүйлийг ер нь эдийн засгийн нүдээр харж бүсээ чангалж байж энэ улс орны яг хөгжлийн суурь тавигдах юм байна лээ л дээ. Тэгээд энэ цаашид энэ хөгжлийн төлөвлөгөө дээрээ энийг анхаарна биз дээ. Түүнээс биш тийм тийм гоё гоё зүйл барилаа тэглээ ингэлээ гээд энэ нэг их тийм сайхан зүйл болохгүй л дээ.

Тэр эртээр тэр Даваасүрэн гишүүний хэлж байгаа гол зүйл дээрээ гишүүдийг анхаарлаа хандуулдаг байх ёстой гэдэг дээр би санал нэг байгаа. Тэгэхгүй хэт сарнисан, хэт гол асуудлаасаа холдсон зүйлүүд их ярьдаг болсон байна. Дэмжиж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Очирбат гишүүнийг нэмье.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ таван жилийн үндсэн чиглэл дээр нэлээн тийм эсрэг байр суурьтай байсан. Ажил хийж чадаагүй. Таван жилийнх нь үр дүн 50 хувьтай, урт хугацааныхаа стратеги төлөвлөлттэйгөө уялдаагүй, Монголын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг зөрчсөн гээд л олон асуудлуудыг хөндсөн. Ерөнхий сайдад бас чуулганы танхим дээрээс хэлсэн. Үүнтэй холбоотойгоор манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Тэмүүлэн дарга бас энэ Улсын Их Хуралд “Чиглэл өгөх” тогтоолын төслийг санаачлаад энэ дээр бас нэлээн тийм дорвитой сайн юмнууд орж ирсэн юм байна гэж магтмаар байгаа юм.

Ялангуяа энэ бас нэг энэ хуулийг мөрдүүлсэн, дунд хугацааныхаа төлөвлөлтийг бас бодитой хийчихье, тэрэнтэй уялдуулсан таван жил, дөрвөн жилийнхээ төсвийг ингээд харчихъя гэсэн асуудлуудыг оруулж ирсэн байсан. Тэгээд дэмжиж байгаа. Яг энэ байдлаар цаашаагаа явахгүй бол Монгол Улс хуульгүй юм шиг явж байгаа. Энэ Ганбаатар гишүүний хэлээд байгаа бас үнэн шүү дээ. Улсын Их Хурал сүүлийн үед энэ Засгийн газрын хуулийн хэлтэс шиг бид нар ажиллаж байна шүү дээ. Хууль зөрчиж асуудлуудыг хуулиар, хуулийг хуулиар зөрчиж оруулж ирдэг тэгээд Их Хурлын гишүүдийг шахдаг, болохгүй байна заавал энийг шийдэх ёстой гэж оруулж ирдэг нэг ийм юм руу л орчихлоо л доо.

Уул нь бид нар чинь энэ Засгийн газартаа ажил хийх гүйцэтгэх засаглалдаа хариуцлага нэхээд сууж байх ёстой, иргэдээ төлөөлөөд сууж байгаа Их Хурлын гишүүд шүү дээ. Тэгээд сүүлийн үед нөхцөл байдал ерөөсөө ийшийгээ орчихлоо. Тэгээд энийг засаж залруулах ёстой, хуулиа мөрддөг байх ёстой, стратеги төлөвлөгөөндөө уялдсан дунд хугацаа, дунд хугацаатайгаа уялдсан таван жил, дөрвөн жил, жилийн төлөвлөгөө гээд явах ёстой тэгээд. Энэ дээр сайшааж дэмжиж байгаа. Их Хурлын эрхэм гишүүд минь энэ “Засгийн газарт чиглэл өгөх” Их Хурлын энэ тогтоолыг төслийг дэмжээд өгөөрэй гэж та бүхнээс хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн дарга сайн ажилласан. Тэмүүлэн гишүүнтэй ажлын хэсэг. Нэгэнт л бид энэ хуулиа биелүүлж таван жилээр төлөвлөдөг болсон учраас гадна талын санхүүгийн зээл олгогч Дэлхийн банк, Европын сэргээн босголтын банк эд нар энэ таван жилийн үндсэн чиглэлд оруулсан ажлууд дээр л хөдөлбө, дэмжбө гэсэн ийм чиглэлтэй бай байгаа. Тийм учраас Тэмүүлэн даргаас 2, 3 асуудлыг асууя.

Тэгээд энэ бол таван жил алдах юм бол маш их хугацаа алдана. Тэгэхээр жишээ нь Монгол Улсын импортын 70, 80 хувь нь явдаг зам байгаа Хөшигийн хөндий, Чойр, Сайншанд, Замын-Үүд гэсэн зам байгаа. Энийг, мөн дээрээс нь Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний хамгийн их тээвэр явдаг, хамгийн олон хүний амь нас хохирдог, машин тэргээ эвддэг Хөшигийн хөндий-Мандалговь, Тавагтолгой, Оюу толгойн чиглэлийн энэ зам байгаа. Энэ хоёрыг Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банк анхаарч байгаа юм билээ. Тэгээд та бүхэн таван жилийн үндсэн чиглэлдээ оруулчихвал одоо олон жил яригдсан учраас ингээд хамтарч ажиллая гэж байгаа юм байна лээ.

Дээрээс нь Тэмүүлэн дарга нөгөө эрчим хүчний Улаанбаатарын эрчим хүчний дэд станцуудын асуудал орчихсон байгаа тийм ээ энэ тогтоол дээр? Хамаагүй тэгээд энэ 3 дээр та нэг хариулаад өгөөч.

Г.Тэмүүлэн: Үндсэн чиглэлтэй холбоотойгоор бид нар бас өнгөрсөн 7 хоногт үндсэн чиглэлийг батлахдаа яг гол хуульд нийцүүлж, хуулийн шаардлага хангасан, төсөв, санхүүжилтийнх нь эх үүсвэрүүд нь тодорхойлогдсон, ТЭЗҮ хийгдсэн энэ төслүүдийг дэмжээд ингээд тодорхой хуулийн шаардлага хангаагүй ч гэдэг юм уу энэ хөрөнгө оруулалтын асуудлуудыг хасаад ингээд явсан байгаа.

Цаашдаа тэгэхдээ бид нар энэ үндсэн чиглэлийг аль болох илүү уян хатан байдлаар, тодорхой энэ засгийн Засгийн газраас дүн шинжилгээ хийгээд эрэмбэ шаардлагаа хангаж байгаа энэ төслүүдийг тухай бүр шийдвэрлүүлж байх энэ зохицуулалтыг бас 5 дугаар заалт дээр оруулж ирж байгаа. Тэгэхээр цаашдаа энэ үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр дээр нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газар өөрөө шийдвэрлээд ингээд явахаар зохицуулалтуудыг хийж өгсөн.

Мөн дээрээс нь ер нь бид бүхний хувьд бас нэг энэ хөрөнгө оруулалтуудыг хийхдээ тодорхой эрэмбэ дараатай байх ёстой, тухайн цаг үеийнхээ эдийн засгийн нөхцөл байдлыг бас бодитоор мэдэрдэг байх ёстой, бодлогынхоо тэргүүлэх чиглэлүүдтэйгээ уялдуулж зарчмынх нь хүрээнд эрэмбэлж оруулж ирдэг байх ёстой гэсэн энэ зарчмуудыг бас мөрдлөг болгосон. Энийгээ ч гэсэн тогтоол дээр бас оруулж өгөөд зөвхөн таван жилийн төлөвлөгөө ч биш ер нь цаашдаа жил бүрийн төсөв, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр ч гэсэн энийг анхаарч байх

ёстой гэсэн зохицуулалтыг бас хуульчилж 6, 5 дахь заалтууд болгож ингэж оруулж өгсөн байгаа.

Энэ маань өөрөө бас нэг талдаа ер нь бид нар бодитоор эрх ашгийн эрэмбээр асуудалд хандаж, бодит нөхцөл байдал дээрээ дүн шинжилгээ хийж асуудлаа шийддэг байх энэ шаардлагыг л бас том зургаараа тавьж байгаа. Мэдээж юу гэдэг юм улс орны эдийн засгийн хөгжилд хэрэгтэй, тухайн эрэмбийн хүрээнд нэг шийдэгдэх ёстой онцгой юу гэдэг юм ач холбогдолтой төслүүдийг бид нар нэн тэргүүнд шийдэж өгөх ёстой. Тэггүйгээр юу гэдэг юм тодорхой ач холбогдол багатай, эдийн засгийн үр өгөөж багатай асуудлуудыг нэн тэргүүнд оруулж ирж эрэмбэ дараалалгүйгээр явуулж байгаа зарчимгүй асуудал маань л бид бүхний хамгийн том асуудал болоод байгаа юм.

Тэгэхээр энийг цааш цаашдаа анхаарч ингэж шийдэж, эдийн засгийнхаа нөөц боломж, бололцоондоо тулгуурлаж хийдэг бай гэдэг энэ зохицуулалтуудыг энэ тогтоолын заалт дээр оруулж өгсөн байгаа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүд байна уу? Асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Лодойсамбуу гишүүн орж байна. Санал хураалтын томьёоллыг уншиж танилцуулъя.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн миний бие танилцуулна.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

12.23 цаг

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийг танилцуулъя. Гонгорын Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Пүрэвдоржийн Мөнхбаяр Монголбанкны Зах зээлийн хэлтсийн захирал, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чулуундаваагийн Чулуунбат Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга, Даваахүүгийн Даваабаяр Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга, хэлтсийн дарга.

Хуулийн төслийн талаар гаргасан хууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлтээ ирүүлсэн байна.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь хэсгийг баримтлан санал хураалт явуулна.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх хууль зүйн зөвлөмжийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт. 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар хот.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 2025 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх хууль зүйн зөвлөмжийг гаргаж, Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороонд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хууль зүйн зөвлөмжийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын ахлах зөвлөх Энхцэцэг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг хууль зүйн зөвлөмжтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар гаргасан хууль зүйн зөвлөмжийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгье.

Очирбат гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар.

Ж.Ганбаатар: Би эрт ирсэн шүү. Тэгээд эхлээд асууж байгаа юм. Энэ анхны хэлэлцүүлэг дээр нь бас тодруулж амжаагүй юм. Тийм учраас Монголбанкнаас энэ 2 төрлийн зээл, нэг нь шатахуун нөгөөдөх нь эргэлтийн хөрөнгө. Энэ зөв ойлгосон байна уу? Нэг нь сав, нөгөөдөх нь эргэлтийн хөрөнгө. Энэ хоёр хоёулаа хэмжээтэй юм уу? Тэр Монголбанкны дарга юм бичиж аваад байна уу, цээжлээд байна уу, тэгээд хэмжээ гэдэг нь хязгаар байгаа юм уу?

2 дугаарт, хүү нь хэд юм? Намайг сайд байхад ийм нэлээн тийм коронагийн үеийн гарсан тийм урт нэртэй хуулиар зохицуулж байсан. Тэр хууль дуусчихсан. Тэгэхлээр энэ тэр хүрээнд 200-гаад тэрбум төгрөг л байдаг байсан гэж надад мэдээлэл өгдөг байсан юм. Тэгээд энэ хэмжээ нь хэд дахин нэмэгдэх юм? Тэгээд хүү нь хэд юм? Тэр үеийн хүүг би бол сайн санаж байна. Тэгээд энэ сав нь ямар их, тэр нөөцийн сав нь Монголбанкнаас гаргах хэмжээ нь хэд юм, нөөц нь хэд юм? Эргэлтийн хөрөнгө гээд байгаа нь тэр нь хэмжээ нь хэд юм, нөөц нь хэд юм? Гэхдээ энэ салбар бас юу л даа бараг 2 тэрбум доллар эргэлддэг байх ёстой гэж би сайд байсан хүний хувьд үзэж байгаа. Эргэлтийн хөрөнгө дээр нь дэмжлэг байх ёстой. Гэхдээ авах сонирхлыг нь хамаагүй төрүүлж болохгүй Дамдинням сайд аа. Яг зайлшгүй үед л авдаг, бусад үед хөнддөггүй л тийм л байх ёстой. Тэгэхгүй бол тийм бас нэг ялгавартай хүүтэй байвал наадах чинь зорилго нь өөр тийшээ явчихна. Тэрийг би ер нь надад намайг сайд байсан хүний хувьд энэ үзэл бодлоо хэлээч гэж олон дарга нар хүссэн учраас би 2 зүйл асуугаадахъя.

Тэгээд Монголбанк энэ надад яг тодорхой хэлээдэх дээ дээд хязгаар гэж байгаа юм уу үгүй юү? Хэдэн их наядаар нь аваад байх боломжтой юм уу, хүү нь хэд юм? 2 төрлийн зээл гэж ойлгож байна тээ? Сав, эргэлтийн хөрөнгө. Эргэлтийн хөрөнгө нь хэд юм, сав нь хэд юм? Тэгээд энэ үргэлжлэх хугацаа нь хэзээ юм? Энэ хугацаа байна уу энэ хуульд? Хязгааргүй юм уу, хэзээ юм? Баярлалаа.

Р.Сэддорж: Эхлээд Монголбанк, дараа нь Дамдинням сайд. 8 номер.

П.Мөнхбаяр: Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Намайг Мөнхбаяр гэдэг. Монголбанкны Санхүүгийн зах зээлийн хэлтэст ажилладаг. Өмнө нь яг энэ КОВИД-ын хуулийн хүрээнд энэ шатахуунтай холбоотой санхүүжилтийг олгоход репо арилжааны хүүгээр олгож байсан. Одоогийн байдлаар энэ репо арилжааны хүү маань 14 хувь дээр байгаа. Бодлогын хүү дээр +2 нэгж хувь. Энэ нь цаашаа банкаар дамжаад гарахдаа +3 хувийн хүүг ингэж олгож явдаг.

Хугацаа болон хэмжээний хувьд Монголбанкин дээр Мөнгөний бодлогын хорооноос шийдвэрлэдэг. Мөнгөний бодлогын хороо тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, аль салбарууд дээр оруулах юм, ямар хугацаагаар олгох юм, ямар барьцааны эсрэг оруулах юм бэ гэдэг бүх шаардлагуудыг нь Мөнгөний бодлогын хорооноос шийдвэрлэж ингэж явдаг байгаа. Тэгэхээр нөгөө тухайн жилдээ нийт гарах санхүүжилтийн хэмжээг Мөнгөний бодлогын хорооноос баталж явдаг гэсэн үг.

Р.Сэддорж: Савны хэмжээний тухай, эргэлтийн хөрөнгө, хугацааны тухай эд нар тодорхой асуусан тийм ээ? 5 номер Дамдинням сайд.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Манай Ганбаатар сайд бас энэ зовлонг үүрч бараг энэнээс хүнд нөхцөл байдлыг туулсан сайд учраас яг асууж байх шиг байна. Нэгэн зэрэг бүхий л төрлийн бүтээгдэхүүн тасарч 2, 3 сар

маш зовлонтой цаг үеийг бид нар туулж байсан. Энэ үед КОВИД-ын хуулийн үйлчлэлийн дагуу нэг удаагийн тусгай хуулиар 400 гаруй тэрбум төгрөгийг гаргаж, урт хугацааны захиалга хийж байж энэ хүндрэлийг давж байсан. Бид яг энэ хуультай ижил хуулийг л оруулж ирж байгаа. Хууль бол 5 жилийн хугацаанд мөрдөгдөнө. 2026 оны 1 сарын 1-нээс 30 он хүртэл мөрдөгдөнө.

2 дугаарт, саванд 500 тэрбум өөрөөр хэлбэл, 200 мянган тонн шатах, тослох материал хадгалах саванд 500 сая төгрөг, түүнийг дүүргэх бүтээгдэхүүнд 590 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай байгаа. Монголбанк хэмжээг нь тогтооно.

Р.Сэддорж: Ганбаатар гишүүн тодруулж асууна.

Ж.Ганбаатар: Тэр хүндрэлийг ч нэг зээл аваад яачхаагүй юм л даа. Тэр чинь манай намайг сайд болохоос өмнө гарчихсан байсан л коронагийн өмнөх асуудал л даа Дамдинням сайд. Би зүгээр нэг зүйлийг Монголбанканд сануулж хэлье. Энэ хязгаар заавал тавих ёстой шүү. Энийгээ тэр Мөнгөний бодлогын хороон дээрээ яриад тэр 200, 300-д нь билүү барих ёстой.

2 дугаарт, наад хүү чинь өөрөө тэр 14 дээр нэмэх нь 3 гэдэг чинь үнэн биз? Тэрийгээ сайн барих ёстой шүү. Хамаагүй хямдхан байх юм бол зээлийн зорилго чинь тэнээд алга болно оо. Шатахуун биш өөр юм болоод яваад өгнө. Өнөөдөр та нар сайхнаар бодож байж магадгүй амьдрал өөрөө наадхыг чинь гуйвуулаад явчихна. Тийм учраас тэр хүү нь бас нэг тийм дөхүү байх ёстой. Авах сонирхлыг нь бууруулах ёстой шүү дээ. Дэмжлэг байх ёстой тэр үнэн ийм зүйл хэлье. Асуулт асуусангүй. Баярлалаа. Амжилт хүсье.

Р.Сэддорж: Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа энэ Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөлтэй танилцлаа. Чуулган дээр анхны хэлэлцүүлэг дээр байж амжсангүй. Дамдинням гишүүнээс 4 асуулт асууя.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын тухай, Улсын нөөцийн тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай гэсэн ийм хуулиуд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Тэгвэл Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1,4-д Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд газрын тосны бүтээгдэхүүний үнэ нь хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх гэсэн, хуулийн бас 13.2-т газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг Засгийн газрын баталсан журмын дагуу бүрдүүлнэ гэж тус тус энэ зааснаас үзэхэд газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх энэ тогтвортой байдлыг хангах асуудлаар хуулиар Засгийн газарт шийдвэр гаргах, зохицуулалт хийх өргөн эрх мэдлийг олгочихсон гэж ойлгож байгаа юм. Өнөөдөр Засгийн газарт яг ямар эрх мэдэл дутаад ийм бие даасан хуулийн төслийг Улсын Их Хуралд оруулж ирж танилцуулж байгаа юм бэ? Энэ хуулиар яг юуг зохицуулах гээд байгаа юм бол оо гэдгийг нэг хариулж өгөөч.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг тусгасан байна. 7.1.3, 7.1.4, 7.1.3 дээр газрын тосны бүтээгдэхүүний импортлогч аж ахуйн

нэгжүүдийн бөөний агуулахад хяналт тавих, түгээх энэ ажлыг шуурхай зохион байгуулах, 7.1.4 дээр энэ хуулийн 7.1.3-д заасан чиг үүргийн хүрээнд импортын бүтээгдэхүүнийг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох гэж зааснаас үзэхэд энэ хуулиар дамжуулаад төрөөс хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд шууд оролцох ийм эрхийг олж авч байгаа гэж ойлгож болох уу? Өөрөөр хэлбэл, төр, аж ахуйн нэгжүүдийн худалдан авсан шатахууныг түгээх юм байна. Борлуулах юм байна гэж ойлгож болох уу?

3 дугаарт нь хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдэд хадгалах савны хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэсэн байна. Тэгвэл энэ хуулийн төслийн 8 дугаар зүйлд Монголбанк газрын тосны бүтээгдэхүүний импортын үйл ажиллагаа эрхлэгчид санхүүжилт олгоно оо гэсэн. Энэ нь Монголбанк аж ахуйн нэгжүүдэд зээл олгоно оо гэж ойлгож байгаа тийм үү? Ийм хэчнээн аж ахуйн нэгжид ямар хэмжээтэй зээлийг ол.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт Дамдинням сайд 5 номер.

Г.Дамдинням: Хуулийн гол зохицуулалтын 2 агуулга байгаа.

1 дүгээрт, нөөц бүрдүүлэх савны хэмжээг нэмэгдүүлэх, манай улсын шатахууны хэрэглээ, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор жилдээ хамгийн багадаа 20 хувь өсөж байна. Савны хэмжээ тэрийгээ гүйцэж өсөхгүй байна. Манай бүх хадгалалт, агуулах савууд бүгдээрээ хувийн хэвшил дээр явагддаг. Засгийн газрын тогтоолоор нөөцийг бүрдүүлэх үүрэг өгдөг. Энэ маань хатуу хариуцлага, зохицуулалт бол санкц байдаггүй. Энэ хуулиар бид ямар зохицуулалт хийж байгаа вэ гэхээр илүү нарийвчилсан зохион байгуулалтыг хийж аж ахуйн нэгжүүдийг үүрэгжүүлэх, мөн бас ямар үед онцгой нөхцөл гэж үзэх юм бэ гэдгээ тодорхой болгож байгаа юм. Хэрвээ та бас хуулийн төслийг харвал импортын хэмжээ 50 хувиас унасан тохиолдолд, дотоодын хомсдол үүссэн тохиолдолд Засгийн газар зохицуулалт хийж орж ирэхээр болж байгаа юм. Ийм зохицуулалт байгаа юм.

Ер нь Австрали, эсвэл Солонгос ч гэдэг юм уу энэ улс орнуудад Шатахууны аюулгүй байдлын тухай хууль гэж байдаг. Энэ нь өөрөө олборлодоггүй, өөрөө нөөцгүй энэ орнууд шууд төр нь оролцож зохион байгуулдаг ийм эрх хэмжээтэй байдаг. Энэ шалгуур нь юу байх юм бэ, яаж зохион байгуулах юм бэ гэдгээ тодорхой болгох зорилготой ийм зохицуулалт энэ хуульд орж байгаа.

2 дугаарт, агуулахыг хянах, хуваарилалт зохион байгуулах зэрэгт оролцох эрхээ засгийг авах ёстой. Стратегийн бүтээгдэхүүн дээр яг одоогийн байгаа үүсчихсэн байгаа нөхцөл байдал юу байгаад байгаа вэ гэхээр хилээр орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүний хэмжээ урьд өмнөхөөсөө их тогтмол байна.

Гэвч жижиглэнгийн үнэ 1 литр нь 3150 төгрөг байна. Дизель түлш бөөний үнэ нь 3500, 3000-3800-гийн хооронд байна. Энэ чинь зах зээл өөрөө хэвийн зохицуулалтад орохоосоо өнгөрчихсөн байдал руу орчихсон байна гэсэн үг. Өчигдөр орой бас аж ахуйн нэгжүүдийг цуглуулж уулзаж энэ асуудлыг ярилаа. Өөрөөр хэлбэл, хомсдолтой байна гэдэг ийм нийгмийн сэтгэл зүйг үүсгээд бөөнөөр худалдан авах аж ахуйн нэгжүүдийн дунд үнэ хаялцуулаад илүү үнэ өгч байгаад нь бөөнөөр нь шууд өгөөд явчхаж байгаа байхгүй юу.

Ингэнгүүт жижиглэн дээрээ тасалдал үүсчхэж байгаа юм. Манай улсын нийт хэрэглээний 38 хувь нь жижиглэнгийн хэрэглээ буюу иргэдийн хэрэглээ. 62 хувь нь бөөний хэрэглээ байдаг. Бөөний хэрэглээ гэдэг уул уурхайн компаниуд, төмөр зам гээд энэ том хэмжээний хэрэглэгчдэд очдог ийм хэрэглээ байдаг. Эд маань нөөцөө бүрдүүлэхийн тулд орж ирсэн бүгдийг нь авч саванд нь хадгалуулах ийм ажил хийгээд байгаа учраас энэ орон нутгуудад, бас Улаанбаатар хотын зарим хэсгүүдэд тасалдал үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр зохицуулалт хийх эрх хэмжээ байхгүй байгаад байгаа юм.

3 дугаарт, дараачийн асуудал юу гээд байгаа вэ гэхээр зарим ШТС-ууд санаатай болон санамсаргүй байдлаар бүтээгдэхүүн байгаа боловч зарахгүй байна. Дотор нь юу байгааг, ямар чанартай зүйл байгааг, хэр хэмжээтэй байгааг хянадаг систем бүх улс орнуудад байдаг. Манайд байхгүй. Цахим ийм системтэй болж Ашигт малтмалын газар дээр нэгдсэн нууцлалтай ийм сантай үүсгэх, бүрэн хянаж байх бодит байдлаар гэсэн үг. Лайв гэж ярьдаг тийм ээ хянаж байдаг аль ШТС-д хэр хэмжээний бүтээгдэхүүн байгаа тухай асуудлыг хянаж зохицуулдаг эрхийг төр бодлогоор хийхээс өөр гарцгүй юм байна лээ. Энийг бусад бүх улс орнууд хэрэгжүүлдэг. Энийг хийх гэж байгаа юм. Улсын хэмжээнд 1800 гаруй ШТС байна. Улаанбаатар хотод 280 гаруй ШТС байна. Бүгд рүү нь хүн явуулж утсаар хэмждэг, үнэн худлыг нь мэддэггүй ийм зохион байгуулалттай байна. Зарим ШТС-ууд дээр очоод хэмжээд үзэхэд нөөцийн үлдэгдэлтэй зүгээр л хаачихсан. Өгөхгүй. Ингээд ард иргэдийн бухимдлыг төрүүлээд байгаа учраас энэ зохион байгуулалтыг энэ салбарын удирдлага өөртөө бас авахаас өөр аргагүй байгаа юм.

3 дугаарт, Монголбанк аж ахуйн нэгжүүдэд зээл олгохгүй. Монголбанк, энэ хугацаа дуусаж.../минут дуусав./

Р.Сэддорж: Нэмж 1 минут.

Г.Дамдинням: Дахиад авчих уу? Импорт болон жижиглэнгийн бөөний худалдаа эрхлэх 180 гаруй зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд бүгдээрээ арилжааны банк руу л хандаж авна. Арилжааны банк бүх шалгуур үзүүлэлтийг нь хянаж үзнэ. Энд Монголбанкнаас репо санхүүжилт буюу зөвхөн шатахуунтай холбоотой зарцуулалтын эх үүсвэрийг арилжааны банкнуудад гаргаж өгнө.

Арилжааны банкнууд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зээлийн хүсэлтийг үнэлж үзээд Мөнгөний бодлогын хороогоороо нэгдсэн хэмжээ гаргаад, мөн бас манай яамны зүгээс бодлогоор энэ бүсүүдэд нөөцийг бүрдүүлэх тухай асуудлыг бас тавина. Өөрөөр хэлбэл, манай улсын нийт дизель түлшний хэрэглээний 50 хувь дангаараа өмнийн бүсэд байна. А-92 бензиний 50-аас илүү хувь нь зөвхөн төвийн бүсэд байна. Энэ бодлогынхоо зохицуулалтыг бид нар тооцоолоод гаргаж өгнө. Ингээд бид бас энэ шатахууны нөөцийн саваа барих ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ийм бодлогын ажлуудаа хийх юм.

Р.Сэддорж: Батчимэг гишүүн тодруулж асууна.

П.Батчимэг: Дамдинням сайдын хариултыг сонслоо л доо. Гэхдээ миний түрүүний хэлсэн нөгөө өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжээд байгаа энэ хуулиудыг хуулиудыг орхиод дахиад нэг ийм хууль гаргаад ирж байгаа нь өнөөдөр сонин сэтгэгдэл төрүүлээд байгаа юм.

Тэгээд саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг үг яах аргагүй зөв, Монгол ардын зөв зүйр цэцэн үг байдаг. Сав бэлдэж өгч байгаа нь сайшаалтай. Савны цаана энэ өнөөдөр импортлогч аж ахуйн нэгжүүд маш олон саад тотгор гадаад ОХУ-аас хамааралтай бензин, шатахууны нийлүүлэлт, тэр хадгалах сав суулга, бүх түгээлт, борлуулалт, жижиглэнгийн энэ олон зам саад тотгорыг давж явж байж өнөөдрийг хүрч байгаа шүү дээ. Гэтэл эргээд тэд нарын нөгөө айлд ороод авдрыг нь уудлаад, ёроолд нь.../минут дуусав./

Р.Сэддорж: 1 минут. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Төрөөс бас аж ахуйн нэгжүүд хувийн хэвшлийн байгууллагуудын зовлонг бас ойлгохгүй л байна л даа. 11 сарын 25-ны өдөр оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг өнөөдөр ингээд Эдийн засгийн байнгын хороо эхний чуулганаар хэлэлцэх асуудал яригдчихсан. Ингээд хүч түрээд явж байгаа нь бас тийм их талархууштай зүйл гэж би харахгүй л байна.

Яг үнэндээ тэр сав нийлүүлэлт, тэгээд тэрний цаана тэр босгох хөрөнгө, санхүүжилт, асар том ажил, процедур явсны дараа аж ахуйн нэгжүүд дээр ямар үр дагавар, сөрөг үйл, үр дагавар үүсэхийг өнөөдөр Дамдинням сайд та төсөөлж сайн бодохгүй л байгаа. Бензин шатахууны хомсдол түр зуур үүсэх энэ байдал дээр л өнөөдөр төр шууд хяналтаа тогтоох ийм маш хурдан арга хэмжээ авч байна л гэж харж байна. Тэрнээс цааш үргэлжлэх тэр үр дагавар, энэ юмыг бас сайн ойлгохгүй байна уу даа л гэж харж байна.

Р.Сэддорж: Үг хэллээ. Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Тодорхой 3, 4-н асуулт асууя. Монголбанкныхан байгаа. Яг энэ энэ хэлэлцүүлгийг ОУВС, Дэлхийн банк ингээд харж байгаа байх. Тэгээд хуулиа зөрчиж хууль санаачилж орж ирж байгаа. Төв банк, Монголбанкны тухай хуулийн 23.1 дээр хориглосон зүйл, заалтуудыг байхгүй болгоод шинээр ингэж оруулж ирж байгаа юм. Энэ дээр ямар байр суурь Монголбанк барьж байгаа юм? Ер нь ингээд цаашаа ингээд ийм байдлаар явах ёстой юм уу? Нэг.

Хоёр гэх юм бол ингээд цаашаа явах юм бол Монголбанк биш Засгийн газрын банк болох гэж байна шүү. Засаг юу хүссэнээ та хэдээр хийлгүүлэх гэж байна? 2 дахь асуулт.

3 дахь нь эх үүсвэрээ яах гэж байгаа юм? Мөнгө хэвлэх гэж байгаа юм уу? Өөр яах юм? Мөнгө хэвлэнэ шүү дээ. Тэгээд гарах үр дүнг нь хэн хариуцах юм? Нөгөө инфляц өснө, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн чинь өсөөд эхэлнэ. 3 дахь асуулт нь энэ.

Яамнаас газрын тос боловсруулах үйлдвэр чинь 2028 онд орно. Дунд хугацааны бодлогын бичиг баримт бүх бичиг баримтууд руу ингээд орчихсон байгаа. Тэгээд 2030 он хүртэл энэ хуулийг хэрэглэнэ гэж байх юм. Энэ ямар утга учиртай юм? Бид нар чинь сүүлийн хэдэн жил өөрсдөө нефтиэ дотооддоо боловсруулаад эцсийн бүтээгдэхүүнтэй больё оо л гээд зориод яваад байгаа биз дээ. Тэгээд энэ хугацааныхаа учир шалтгааныг нэг Дамдинням сайд хэлчих хэрэгтэй.

2 дугаарт нь ер нь энэ зах зээлийг нь чөлөөлбөл яасан юм. Одоо яг чоно борооноор гэж байгаа юм шиг энэ хэдэн аж ахуйн нэгжүүдийг шахах гэж байгаа юм

шиг л зүйл, заалтууд орж ирээд байх юм. Аль болох либералчлах бодлого барь л даа. Гаднын компаниудыг оруулж ирэх бодлого барь л даа. Өнөөдөр Монголбанкнаас дээр ч гэсэн тэр шүү дээ. Гаднын банкныг оруулж ир гэхээр хуулиа зөвшөөрчихсөн гээд журмаараа та нар хаачихсан байгаа. Энэ Их Хурлын шинэ дарга хэлээд л байгаа шүү дээ. Яг тэрэнтэй адилхан юм явж байна шүү дээ. Тэгээд энийгээ чөлөөлж хэзээ нээх юм, ямар бодлого барьж байгаа юм? Энэ 6 асуултад хариулт авчхаад тодруулъя.

Р.Сэддорж: 6 асуулт. Тодорхой асуулаа. Дамдинням сайд.

Г.Дамдинням: Энэ Монголбанктэй холбоотой асуудлаар Монголбанкныхан хариулчихна биз дээ. Яах вэ зүгээр газрын тос боловсруулах үйлдвэрийн маань ажил эрчимтэй явж байна. Газрын тосны үйлдвэрлэл бол бидний шатахуун, энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой маш том бүтээн байгуулалт санаачлагдаж явж байна. КОВИД-ын үед нэлээн удааширсан. Одоо энэ үйлдвэрийн маань ашиглалтад 2028 онд орно. Энэ үйлдвэрийн маань хүчин чадал манай нийт хэрэглээний 50 хувийг л хангана.

Үйлдвэрийн анхны ТЭЗҮ нь тийм. Цаана нь дахиад 50 хувийг бид нар импортоор авахаас өөр арга байхгүй. Манай одоогийн хэрэглээ бол 100 хувь импортоор байна. Эндээс 95 хувь нь ОХУ-аас байгаа Очирбат гишүүн ээ. Тэгээд яах вэ яагаад 5 жилийн хугацаанд бид нар энэ хуулийг мөрдье гэж оруулж ирж байгаа вэ гэвэл олон улсын геополитикийн нөхцөл байдал тогтворгүй ийм нөхцөл байдалтай байгаа учраас шаардлагатай үед бид нар 3 сараар, 6 сараар, их хэмжээгээр захиалга хийж, хэйж гэж ярьдаг тээ нэг тогтчихсон үнээр ингэж захиалга хийх ийм л зайлшгүй шаардлага үүсчхээд байгаа юм. Энийг өмнө нь бид нар хийж байсан.

Шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийг бас хэт их том гэж хараад байдаг юм шиг байгаа юм. Нэг сар орчмын хэрэглээний эх үүсвэртэй хүмүүс юм эд нар. Тэгээд энийгээ 12 удаа эргэлдүүлж л бидний хэрэглээг хангадаг. Төр энийг хийнэ гэвэл энэ их хэмжээний төсөв бид нар тавих ёстой болно. Дээрээс нь ууршдаг энэ бүтээгдэхүүний хулгай зэлгий нь дийлддэггүй юм байна лээ. Тэгэхээр энийг зах зээлийнх нь зарчмаар хувийн хэвшлийнхээ суурь дээр явуулахаас өөр гарцгүй. Зөв. Энэ нь хамгийн зөв гарц.

2 дугаарт, үнийн либералчлалтай холбоотой асуудлыг их яриад байгаа юм. Зүгээр олон нийтэд мэдээлэл өгөхөд ний нуугүй хэлэхэд шатахуун бол маш чөлөөтэй байгаа. Зөвхөн 60 мянган тонн АИ-92, К-2 буюу Евро-2 стандартын бензин дээр 705 долларын, 1 тонныг нь 705 доллароор авдаг гэрээг ОХУ-ын Роснефтьтэй бид нар мөрдөөд явж байгаа. Бусад бүтээгдэхүүнүүд өөрөөр хэлбэл, Евро-92, бусад дизелийн түлш, пропан, газ энэ тэр бүгд дээр ямар нэгэн үнийн хязгаарлалтгүй явж байгаа. Либерал л байгаа шүү дээ ер нь бол. Тантай санал нэг байна. Зах зээл өөрийнхөө зарчмаар явах ёстой.

Гэхдээ бас ард иргэдийнхээ энэ түрүүн хэлж байна шүү дээ. Бөөний үнийг нь жижиглэнгийн үнээс хэт өндөр болгоод багцаар нь аваачиж ингэж явуулаад зах зээлийн горимыг алдагдуулж байгаа бол шударга бус өрсөлдөөн, монополтой холбоотой асуудлууд төр хяналтаар орохоос аргагүй. Энэ онцгой бүтээгдэхүүн байхгүй юу. Онцгой бүтээгдэхүүн. Импортлох эрхтэй 160 гаруй, 180 гаруй аж ахуйн нэгжүүд байна.

Хүмүүс бас яриад байгаа юм энэ чөлөө зөвшөөрлийг нь чөлөөлөөч. Манай яаманд стандартаа хангаад хүсэлт тавьсан болгон зөвшөөрөл өгч байгаа. Бүгдээрээ авч болно. Импортоор оруулж ирж чадах болгон нь аваарай зөвшөөрлийг. Стандарт бүрдүүлэх ёстой.

Яагаад гэвэл энэ чинь тэсэрч, дэлбэрэх аюултай бодис байхгүй юу. Тээвэрлэх нь хүртэл аюултай. Би олон нийтэд хандаж бас нэлээн хэдэн удаа хэлсэн. Дахиад хэлье. Дүнжингаравын дэлбэрэлт энэ бас л энэ шатах, тослох материалын бүтээгдэхүүнийг аюулгүй зөөх стандарт алдсанаас болж үүссэн дэлбэрэлт. Хэд хэдэн хүний алтан амь аваад одсон.

Тэгээд энийг бас стандартгүйгээр шаардлага хангаагүй аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг шууд өгч бас болдоггүй. Шаардлагаа хангасан, бүрдлээ бүрдүүлчихсэн байгаа бол бараг өдөрт нь өгч байгаа юм. Бид нар ерөөсөө хязгаарлалт хийхгүй байгаа шүү гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Монголбанк 8 номер.

П.Мөнхбаяр: Очирбат гишүүний асуултад хариулъя. Тантай санал нэг байна. Ер нь Монголбанк, ер нь дэлхийн ер нь аль ч улс орнуудын Төв банкнууд дээр бодлогын болон үйл ажиллагааны бие даасан байх хараат бус байдал гэж хангагдах ёстой. Энэ одоо байгаа Төв банкны хуулиараа ч гэсэндээ ер нь энийг зохицуулж энэ хориглох зүйлүүдтэй холбоотой заалтуудыг нь оруулж ирсэн гэж үзэж байгаа.

Ер нь бол энэ урт хугацаа репо хэрэгсэл бол анх КОВИД-ын үед анх гарч ирээд тэгээд одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, энэ журмаар явж байгаа ийм хэрэгсэл байгаа. Энэний хүрээнд энэ шатахуунтай холбоотой энэ санхүүжилтийг нэмж оруулъя гэсэн саналыг гаргаад хуулийн санаачилга холбогдох яамнаас нь гарсан гэж ойлгож байгаа. Тэгээд Монголбанкны хувьд мэдээллүүдээ өгөөд энэ хэрэгслүүд дээр ямар шаардлагууд тавьдаг, энэнтэй холбоотой ажлууд дээрээ оролцоод явж байгаа.

Хэмжээний хувьд мэдээж би өмнө нь хариулсан. Мөнгөний бодлогын хороон дээрээс.../минут дуусав./

Р.Сэддорж: Нэмж 8 номер, 1 минут.

П.Мөнхбаяр: Хэмжээ, хүү, хугацаа гээд бүх барометруудийг нь Мөнгөний бодлогын хорооноос тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, зах зээл дээр үүсэж болох нөхцөл байдал, инфляц, ханш гээд бүх зүйлүүдийг тооцож үзсэний үндсэн дээр хэсэгчилж олгох юм уу, бүрэн хэмжээгээр нь олгох юм уу, дээд хэмжээ нь ямар байх юм бүх зүйлүүдийг нь Мөнгөний бодлогын хорооноос хязгаарлалтуудыг нь тогтоогоод явдаг.

Эх үүсвэрийнх нь хувьд энэ нөгөө арилжааны банкнууд дээр байгаа, өөр дээр нь байгаа үнэт цаас болон бусад барьцаа хөрөнгө, хүлээн зөвшөөрөгдсөн барьцаа хөрөнгийнх нь эсрэг санхүүжилт олгодог. Өөрөөр хэлэх юм бол, түр хугацаан дээр манай дээр үнэт цаасаа худалдаад тэгээд эх үүсвэр авч цаашаагаа зээл олгочхоод буцаагаад зээл нь төлөгдөхөөр үнэт цаасаа буцааж худалдаж авах энэ хэлцлийг ер нь бол урт хугацаатай репо хэлцэл гэж ойлгож байна.

Р.Сэддорж: Очирбат гишүүн тодруулж асууна.

Г.Очирбат: Тэгээд харин ингээд асуулт асуухаар санал нэг байгаа л гээд байгаа юм. Тэгээд санал нэг байгаад байгаа юм бол энэ буруу шийдвэрүүдээ зогсоочих л доо. Төв банкны хуулийг ингэж оролдож яах гээд байгаа юм бэ. Наадах чинь олон улс харж байгаа шүү дээ Монголбанкныхан. Энэ их эвгүй юм руу явна шүү хойшид хойшдоо. Дуртай нь орж ирээд одоо би түрүүн бас хэлсэн Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын хуулийн хэлтэс шиг ажиллаж байгаа шүү гэж. Засгийн газрын банк боллоо Монголбанкныхан. Бодоорой та хэд маань.

Би энийг дэмжихгүй байгаа. Хориглох зүйл, заалтуудыг энийг байхгүй болгоно гэдэг энэ чинь аягүй тийм үр ашиг нь, үр уршиг нь бараг ойрын хугацаанд ирнэ дээ. Та хэд хараарай. Одоо ингээд төсвийн нөхцөл байдал эвгүйтээд ирнэ, бүх юм ингэж шахагдаж орж ирнэ. Тийм биз Ганбаатар гишүүн ээ? Бүх сайд нар чинь ингэж орж ирнэ. Тэгээд л асуудал болохоо болилоо гал унтраах ёстой гээд яваад байдаг. 1 минут сунгачихъя тэгэх үү?

Р.Сэддорж: 1 минут Очирбат гишүүн.

Г.Очирбат: Тэгээд дайрдаг. Тэгээд шийдэхээс өөр аргагүй гэж шахдаг, шийдүүлдэг. Яг өнөөдөр үнэнийг хэлэхэд манай Засгийн газар сайд нарт хүч, бяр нь байгаа шүү дээ. Ажлаа хий л дээ Дамдинням сайд аа. Тэр аж ахуйн нэгжүүдээ загнаж байхаар цуг суугаад хэдүүлээ яах вэ гарц, гаргалгаагаа ярь л даа. Та хэд өөрсдөө арилжааны зээлийг аваад ингээд явах бололцоо байна уу байхгүй юу? Тэрийг нь асуу л даа. Энэ олон жил манай энэ нефть импортолж байгаа компаниуд чинь эдийн засгийн хувьд хүчирхэг болчихсон байгаа. Аль ч арилжааны банк руу, аль ч олон улсын банк руу хандахад мөнгө олоод ирэх бололцоотой байгаа шүү дээ. Заавал Монголбанкаар оролдож яах гээд байгаа юм бэ Төв банкныхаа тухай хуулиар? Энэ Төв банкныхан аягүй эвгүй байдал руу орж байгаа шүү. Танай би дахин дахин л хэлж байгаа эвгүй байдал руу орж байгаа. Та хэд ингээд хойшдоо Засгийн газрын банк боллоо. Тэгэхээр энэ дээр Их Хурлын гишүүд, мэргэжлийн Байнгын хорооныхон анхааралтай энийг ажиглаж, зөв шийдвэрүүд бид нар гаргаж яваад зарим унагаах юмаа унагаагаад явахгүй бол уршиг нь үнэхээр хүнд болно шүү.

Р.Сэддорж: 5 номер.

Г.Дамдинням: Очирбат гишүүн ээ бид сайдын хувьд, Засгийн газрын хувьд яамны хувьд аж ахуйн нэгжүүдтэйгээ ер нь өдөр шөнөгүй л зууралдаж байна. Ёстой нөгөө хатуу, зөөлнийг хослуулаад л засаглаж байна даа. Удирдаж байна. Бүх чадлаараа л оролдож байгаа. Улсын нөөцөөс дэмжиж байна. Улсын төсөв дээр бас эх үүсвэр дээр нь дэмжлэг үзүүлэх та хөрөнгө тавьж байна. Энэ хөнгөлөлттэй зээлээр дэмжихээс өөр арга байхгүй. Энэ хууль яагаад зайлшгүй гарч байгаа вэ гэхээр манай улсын өөрийн онцлог байна. Бид нар 100 хувь гаднаас хараат байхгүй юу шатахууны. Хэрвээ бид нар энд зээл өгөөд буцаагаад авдаг хэмжээгээр л хийхгүй бол улсын төсөв дээр тавих уу? Дийлэхгүй шүү дээ бид нар. 3 сарын захиалга өгөх хэмжээний чадал энэ аж ахуйн нэгжүүдэд байхгүй. Зээлийн зохист харилцаагаа эд нар дийлдэггүй юм. КОВИД-ын үед энэ арга хэмжээг авч байсан юм. Улсын маань онцлог, байгаа нөхцөл байдал нь энэ. Үнэгүй мөнгө хэнд ч өгөх гээгүй шүү дээ. Өөр гарцгүй болчихоод байна.

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн нэрээ татаж байгаа тээ? Ингэнэ Цэнгүүн гишүүн. Татсан уу? Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өмнөх гишүүдийн асуулттай ерөнхийдөө давхацсан байгаа юм. Тэгээд үндсэндээ бид нар энэ стратегийн бүтээгдэхүүн гэж нэрлээд ирэхээрээ л манай улс ер нь энэ тухайн бүтээгдэхүүнийг нэг тусгайлж авч байгаад тэгээд тэр тусгайлж авахдаа үнийг нь хянадаг болж байгаа юм. Үнийг нь хянадаг байж байгаад одоо болохоороо энэ түгээх, борлуулах ажиллагаа дээр нь ч гэсэн бас хяналтууд тавиад ороод ирнэ гэдэг чинь өөрөө ер нь ямар ч эдийн засгийн ойлголтын хувьд ердөөсөө төрийн мэдэлд 100 хувь шилжиж байна л гэсэн үг. Ойлголт болчихоод байна л даа. Тэгээд ингээд бензин, түлш хомсдоод байгаатай холбоотой яаралтай шийдвэрлэх ёстой юу ёстой, бид бүхэн савны энэ хэмжээгээ нэмэгдүүлэх ёстой юу ёстой.

Гэхдээ энийгээ дагаж Засгийн газрын бүрэн эрх гэдэг ийм байдлаар оруулж ирж байгаа ч өөрөө байж боломгүй. Энийг эсэргүүцэж байгаа юм. Тэгээд энэ бүрэн эрх дээр нь бүтээгдэхүүнийг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох гээд энэ зүйлийг хүртэл ингээд оруулаад ирж байгаа нь онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэж байгаа юм. Гэхдээ манай улсад ямар тохиолдолд онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзэх юм, үзээгүй юм гэдэг чинь өөрөө тодорхойгүй. Нэг ийм жишгийг бид нар нэвтрүүлчихээр буцаад энэ чинь өөрөө буцах боломжгүй болчихно. Ингээд гурилыг ч тэр, махыг ч тэр бид нар стратегийн бүтээгдэхүүн гээд л нэрлэдэг. Эрчим хүчийг ч тэр стратегийн бүтээгдэхүүн гээд л нэрлэдэг.

Тэгээд ингэж оруулж байгаад үнийг нь бид нар зохиомлоор барьдаг. Энийг хэрэгжүүлэх компаниуд дээр нь тусгай зөвшөөрөл гэж хэдхэн компанид тусгай, монопол эрх олгодог. Ингээд олигополит зах зээл үүсчихдэг энэ компаниуд нь өөрсдөө авч явж чадахгүй гээд энэ байдлаасаа бид нар гарахад төр оролцохгүй байгаад байгаа болохоор энэ хомсдол үүсээд байгаа биш, ердөөсөө төр өөрөө хэтэрхий оролцоод төр хэтэрхий ихээр энэ зах зээлүүдийг барьснаас болж энэ асуудал чинь үүсээд байгаа шүү дээ Дамдинням сайд аа.

Та бас энийг чөлөөт зах зээлд бас ойлгодог хүн учраас ойлгож байгаа байх гэж бодож байна. Энэ тасалдал үүсээд байгаа үндсэн шалтгаанаа бид нар зөвөөр тайлбарлахгүй бол олон жилийн турш үнийг, дээрээс нь ямар компаниуд энэ зах зээлд оролцохыг нь төр өөрөө зохицуулж ирснээс болж энэ өөрөө үүсээд байгаа асуудал шүү дээ.

Р.Сэддорж: 5 номер.

Г.Дамдинням: Тийм яах вэ мэдээллийн л асуудал байгаа. Ер нь бид нар оролцох ёстой юм, оролцох ёсгүй юм байна. Би одоо санал нэг байна. Тэгээд либерал, чөлөөт зах зээлийг дэмждэг үзэл бодолтой хүн. Гэхдээ чөлөөт зах зээлийг дэмждэг бүх улс орнууд шатахуун дээр тусгайлсан зохицуулалт хийж байна. Энэ хуулийн төсөл дээр ямар нөхцөлд онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзэх вэ гэдгийг тодорхой заачихсан байгаа. Импорт 100 хувь манайх хараат байдаг. Импортын хэмжээ 50 хувь унах юм бол тусгай горимоор зохицуулалт хийж явна гэдэг ийм л зохицуулалт оруулж ирж байгаа. Түүнээс байнга хянаад байна гэсэн ойлголт байхгүй.

Зарим саруудад бидний импортлогч орны дотоод нөхцөл байдлаас шалтгаалаад импорт сардаа 50 байтугай доошоо хувь уначхаж байгаа. Энэ үед бид нар бөөний худалдааг нь шууд ингээд дэмжээд явуулчих юм бол иргэдэд тасалдал үүсчхээд байгаа юм. Гол асуудал энд байгаа юм. Би та бүхэнд хэлье л дээ өнгөрсөн 11 сард улсын хэмжээнд 75.2 мянган тонн АИ-92 авто бензин орж ирсэн. Энэ манай ердийн хэрэглээ 68 мянган тонн байхгүй юу сарын. Энэнээс 7 мянган тонноор илүү байхад хүрэлцэхгүй байна. Зохицуулалт шаардлагатай. 12 дугаар сарын эхний 8 өдрийн байдлаар 16 мянган тонн АИ-92 импортоор орж ирсэн. 11 сард 124.2 мянган тонн дизель түлш орж ирсэн. 12 дугаар сард 134 мянган тонныг захиалчихсан байна. Одоо 8 өдрийн байдлаар бид нар 50 мянган тонныг оруулаад ирчихсэн байна. Өөрөөр хэлбэл, нийт захиалсныхаа бараг 40 орчим хувийг оруулаад ирсэн.

Тэгэхэд би түрүүн хэллээ шүү дээ зах зээл маань аж ахуйн нэгжүүд маань өөрсдөө бас зах зээлээ эвдээд байгаа байхгүй юу. Ямар ч бараа, бүтээгдэхүүний энэ бал 100 төгрөгийн үнэтэй байхад, 1 ширхэг нь 100 төгрөгийн үнэтэй байхад 100 ширхэг нь 120 төгрөгөөр зарагдаад байгаа байхгүй юу. Нэгжийн үнээсээ бөөний үнэ нь илүү гараад хэн илүү их мөнгө төлж байгаад нь өгөөд картель үүсгээд байгаа бол төр зохицуулахаас өөр аргагүй. Ямар ч улсад монополын хуулиа ажиллуулна. Тухайн салбар өөрөө энэ хяналт зохицуулалтаа хийхээс өөр аргагүй байдал руу орчихоод байгаа юм.

Тэгэхээр улсынхаа онцлогийг эрхэм гишүүд маань бас бодож үзээч. Австралид Бензиний аюулгүй байдлын тухай хууль гэж байгаа. Шатахууны аюулгүй байдлын тухай хууль гэж байгаа. Адилхан либерал чөлөөт зах зээлтэй орон. АНУ-д бий. БНСУ-д бий. Энэ хуулиуд дээр бүгд дээр нь л ийм зохицуулалт байгаа. Онцгой нөхцөл буюу импортын хэмжээ буурчихсан нөхцөлд бид нар хяналт, зохицуулалтыг аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтарч хийнэ. Аж ахуйн нэгжүүдтэйгээ энийг байнга л яриад явж байгаа шүү дээ.

2 дугаарт, дараачийнх нь бид үнийг ерөөсөө барихгүй байгаа. Оролцохгүй байгаа. Аль болох оролцохгүй байхыг хичээж байгаа. Тэгэхдээ төрийн бодлогоор бид нар сав, суулгыг нэмэгдүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлэхгүй бол тэрийг нь удирдаж, зохион байгуулж, бодлогоор дэмжихгүй бол бас болохгүй байна. Аль бүсэд хэр хэмжээнийхийг барих юм, аль бүсэд ямар дэд бүтэц тавьж байж бид нар хүрэлцэх юм, хаана нь бид нар хөнгөлөлт өгөх юм, хаана нь өгөхгүй юм бэ гэдгээ бид нар зохицуулахгүй бол манай зах зээл маань өөрөө оруулж ирдэг 20-оод компанийнхаа нуруун дээр ингээд тогтчихсон. Тэр компаниуд маань заримдаа бас ингээд яг үнэнийг хэлэхэд бас болохгүй байна. Би бас энэ өөрөө энэ хуулийг хугацаатай тавьж байгаа шалтгаан нь ч энэ. Үйлдвэр ашиглалтад орчих юм бол энэ хууль бараг тэгээд болих талдаа орох биз дээ. Тэгээд зах зээлээр нь явуулахыг хичээж байна. Гэхдээ бас нөхцөл байдал тулчхаад байгаа учраас арга буюу л оруулж ирж байгаа гэдгийг ойлгоорой гишүүд минь.

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн тодруулж асууна.

С.Цэнгүүн: Энэ манай улсын нөхцөл байдлаас болоод бид бүхэн зайлшгүй энэ Засгийн газар бүрэн эрх олгоод энэ асуудал энэ одоо бүүр жижиглэн рүү хүртэл орох юу нь нийлүүлэлтийн хэмжээ нь 50-аас доош хувь буурсан тохиолдолд манай Засгийн газар маань бүрэн эрх аваад энэ түгээх, хянах бүүр агуулахууд сав суулгад нь хяналтаа тавиад эхлэх юм байна. Тэгээд энэ процесс боллоо гэж бодъё л доо өнөөдөр. Энэ бүх үйл явдлууд болчихлоо, аж ахуйн

нэгжүүд маань саваа зээлээр авчихлаа. Тэгээд байж байтал нийлүүлэлт хангалтгүй болоод ирлээ. Тэр үед Засгийн газар жишээ нь би төрийг энэ хяналтын үйл ажиллагааг хийж чадна гэж ерөөсөө итгэхгүй байна л даа. Тэгэхээр яг ямар хүмүүс нь очоод ямар арга замаар юу хийж хяналтаа тавих гээд байгаа юм? Тэр процесс нь юу юм бэ сайд аа?

Р.Сэддорж: 5 номер.

Г.Дамдинням: Энд процессыг маш тодорхой ойлгох хэрэгтэй. Өнөөдөр Монгол Улсад 1800 орчим ШТС-ууд байна. Аж ахуйн нэгжүүдийн агуулахууд байна. Улаанбаатар хотод 280 орчим ШТС-ууд байна. Энэ бүхэнд ямар чанартай хэр хэмжээний бүтээгдэхүүн очоод хэр хэмжээнд зарагдаад хэд нь үлдчихээд байгааг бид мэдэхгүй байгаа. Аж ахуйн нэгжүүдэд өөрсдөд нь хяналтын систем байдаг юм байна лээ. Улсын хэмжээнд бид хаана юу байгаагаа энэ стратегийн бүтээгдэхүүнийхээ нөөцийн хяналт, удирдлагыг мэдэхгүй. Хүн явуулж хянаж байгаа. Их олон тохиолдолд ШТС-ууд зарахгүй барьчихсан тохиолдлууд байна. Энэ нь сүүлдээ бас улс төрд ч нөлөөлөх нөхцөлүүд үүсдэг. Тэгэхээр энийгээ бид нар бас хаана юу байгаагаа харж, зохицуулалтаа хийж, аль бүс рүү илүү түлхүү явуулах вэ, аль бүс рүү түлхүү явуулахгүй вэ гэдгээ хянахгүй бол сошиалаар шуугьсан нэг ийм л юм руу явчихаад байгаа байхгүй юу. Бодит тоо баримттай болъё, хардаг байя л гэж байгаа юм.

Р.Сэддорж: 1 минут хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учраас 1 минут.

С.Цэнгүүн: Үгүй тэгээд одоо ингээд бид нар хүн явуулаад тэр шатахуун борлуулж байгаа цэгүүддээ хяналт тавина гээд байгаа юм. Тэгээд тэр хүн чинь зүгээр авлигал аваад л байхгүй болчихно шүү дээ. Хэрвээ байгууллагууд өгөхгүй дээрээ тулах юм бол өгөхгүй гээд л тухайн ирсэн хүнд нь мөнгө өгөөд л тухайн асуудлыг шийдвэрлээд л явчихдаг юм шүү дээ. Манай төр дандаа л тийм байдлаар л хяналт хэрэгжүүлж байж тэгж байгаа гэдэг нэрээр нэг хэдэн хүн мөнгө аваад л явчихдаг. Тэгээд л алга болчихдог биз дээ. Тэгэхээр чинь яг ямар байдлаар хяналт тавих гээд байгаа юм гэдэг чинь ойлгомжгүй байна шүү дээ. Хүн явуулаад хяналт тавина гэдэгт бол итгэхгүй байна.

Р.Сэддорж: Үг хэлчихлээ дээ. Үг хэлчихлээ. Харин тийм одоо ингээд Дамдинням сайд ингээд гишүүд дэмжээд байна шүү дээ. Та өөрөө болохоороо юу яагаад байх юм. Ийм учраас дэмжиж байгаа. Энэ хүнд үед ийм хууль гаргах нь зөв байх.

Тэгээд энэ кокос, химийн үйлдвэр, аж үйлдвэрийн парк эд нар чинь хаана яваад байгаа юм? Хэчнээн жил ярив аа? Танай яам тэн дээрээ анхаарч байна уу? Нүүрснээс түлш гаргахад Монголын эрдэмтэд бэлэн байгаа, шинжлэх ухааны докторууд бэлэн байгаа. Тэгээд энэ дээр юу анхаарч байна аа? Энийгээ та бүхэн бодооч би тэгээд үг хэлж байгаа. Дээрээс нь энэ сав суулгаа бэлдэлгүй яах вэ. Саалиа бэлдэхээр саваа бэлд гэж маш зөв. Тэгээд өөр эх үүсвэрүүд хайж саваа бэлдэж байгаа байлгүй, бэлдэх байлгүй. Ингээд хөнгөлөлттэй зээл гарч байгаа гэж ойлгож байгаа.

Дээрээс нь тэр Алтанширээгийн аж үйлдвэрийн парк, нөгөө нефтийн үйлдвэр 28 он удахгүй гарлаа, гарна. Нөгөө Энэтхэгчүүд хүлээлгэж өгөөд явчихна. Энэ дээрээ та бүхэн маань их анхаарч байгаа биз дээ? Энийгээ давхар Их Хурлын

хэмжээнд, Байнгын хорооны хэмжээнд асуудал оруулж ирэх хэрэгтэй байх гэж бодож байна.

Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь хэсгийг баримтлан санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо, эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо дэмжиж, санал, дүгнэлт гаргасан гэж заасны дагуу хураалгах зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох.

11.1.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалтад гишүүд бүгд орсон уу? Санал хураалт.

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганзориг уншиж танилцуулна.

Хэлэлцэх асуудал. Дараагийн асуудалдаа оръё.

13.08 цаг

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгээс хагас коксожсон шахмал түлшний асуудлаар Эрчим хүчний сайдад тавьсан асуулгын хариуг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Амгаланбаярын Амартүвшин Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдол хариуцсан орлогч, Даваасамбуугийн Мөнхбаатар Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга, Нямын Наранбаатар Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, Цэдэндамбын Эрдэнэбаяр “Тавантолгой түлш” компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Хишигтогтохын Ариунзаяа “Тавантолгой

түлш” компанийн Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Чимэдийн Буянжаргал Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер, Пүрэвжавын Давааням Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч.

Асуулгын хариултыг танилцуулахыг урьж байна. Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн Төрийн нарийн бичгийн дарга. Микрофоныг нээе 5 номер.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113.3.3-д нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд нэмэлт өгөөд хариулт тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асууж, тайлбар авах, түүнд хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байна.

113.3.4. Асуулгад хариулт өгсний дараа асуулга тавьсан гишүүн 1 удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ гэж заасан байна.

Ерэн-Өлзий дарга хаа байна? Хэдэн номер? 5 номер микрофон.

Б.Ерэн-Өлзий Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий. Баатархүү гишүүнээс ирүүлсэн асуулгатай холбоотой мэдээлэл өгье.

Баатархүү гишүүнээс ирүүлсэн нийт 8 асуулгын 2 нь чиг үүргийнхээ дагуу Эрчим хүчний яаманд хамааралтай байгаа.

Засгийн газрын 24 оны 6 сарын 6-ны өдрийн 248 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 24 оны 8 дугаар сарын 30-ны 27 дугаар тогтоолоор “Тавантолгой түлш” компанийн төр эзэмшлийн хувь хэмжээ нийслэлийн өмчид шилжсэн. Эрчим хүчний яаман дээр байсан чиг үүргүүд нийслэл рүү шилжсэн байгаа.

Асуулгын 7, 8 дугаар асуулгууд нь Эрчим хүчний яамны чиг хүрээнд дараах мэдээллийг бидэнд хүргүүлж байна.

Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой Эрчим хүчний яамны зүгээс дараах арга хэмжээнүүдийг шат дараалж хэрэгжүүлж байна. Гэр хорооллын айл өрхүүдэд цахилгаан халаагуур ашиглах, аль болохоор шатах түлш ашиглахгүй байх боломжийг бүрдүүлэх хүрээнд арга хэмжээнүүдийг 2016 оноос эхлээд тогтмол авч ирсэн. 17-гоос 19 онд Улаанбаатар хотын яг утааны цөм хэсэг болж байгаа хойд хэсгийн айл өрхүүд болох нийт 41 мянган айл өрхийг цахилгаан халаагуураар халаах боломжийг бүрдүүлэх ажил Эрчим хүчний яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн.

Гэр хорооллын эдгээр цахилгаан халаагуураар халаах боломж бүрдсэн айлуудын цахилгаан хэрэглээг дэмжих үүднээс 2017 оны Засгийн газрын 199 дүгээр тогтоолоор гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифыг хөнгөлөх ийм журам батлагдсан. Энэ журмын хүрээнд оройны 9 цагаас өглөөний 6 цаг хүртэл айл өрхийн цахилгаан хэрэглээний тодорхой хязгаар хүртэл хувь, хэмжээг 100 хувь хөнгөлж ирсэн.

Эрчим хүчний үнэ тариф 24 оны 11 сард нэмэгдсэнтэй холбогдуулаад шөнийн тарифаар энэ зохицуулагдаж, цахилгаанаар халаалтаа шийдэж байгаа айл өрхүүдэд тодорхой хүндрэл үүссэн тул 25 оны 2 дугаар сарын 26-ны Засгийн газрын тогтоолоор энэ тарифт нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Үүгээрээ болохоор айл өрхүүдэд 100 хувийн хөнгөлөлт үзүүлэх 1 сарын хэрэглээний дээд хязгаарыг 220 киловольтын хүчлийн түвшиндээ хэрэглэгчид 700 квт/цаг байсныг 1500 болгож нэмэгдүүлсэн. 380 вольтын хүчлийн түвшиндээ хэрэглэгчдэд 1500.../минут дуусав./

Р.Сэддорж: 5 номер нэмж минут өгье.

Б.Ерэн-Өлзий 1500 квт/цаг хязгаар байсныг 3 мянган квт/цаг болгох шийдвэрийг гаргасан. Үүгээр айл өрхийн цахилгаан халаалтдаа цахилгаан хэрэглэх ийм бас санхүүгийн хөшүүргийг яамны зүгээс дэмжиж ажиллаж байна. Үүнээс гадна энэ хөнгөлөлтөд зориулсан цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийг улсын төсөвт бас тусган энэ хөнгөлөлтийн асуудлыг зохицуулдаг. 26 онд 70.7 тэрбум төгрөгийг төсөвт тусгасан байгаа.

Зөвхөн цахилгаан халаагуураас гадна гэр хорооллын Цахилгаан түгээх сүлжээний хүчин чадалтай холбогдох бас хэрэглэгч өөрөө үйлдвэрлэгч боломжийг дэмжих үүднээс гэр хорооллын айл өрх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс өөрийгөө хангах, илүүдлээ түгээх сүлжээ.../минут дуусав./

Р.Сэддорж: Ерэн-Өлзий дарга маш тодорхой гишүүдийн асуултад хариулаарай. Яг Дэгийн тухай хуулиар хугацаа нь ингэж таарч байна.

Асуулгын хариутай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Баатархүү гишүүнээр тасалъя. Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Энэ агаар орчны бохирдлыг бууруулах ажил маш чухал ажил. Олон жил олон дарга нарыг лобби хийж татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарах болгосон төсөл. Үүний жишээ бол 2018 онд хэдэн тэрбумаар юм мэдэгдэхгүй нийслэл хот нуугаад байгаа сайжруулсан түлшний үйлдвэрээ хаачихсан. 2 газар байгуулсан. Одоо байгаа мэдээллээр 1.5 их наядын өртэй энэ үйлдвэр. Энэ өрийг мөн татвар төлөгчид төлнө. Тэгээд энэ үйлдвэр хааж байна гэдэг бол энгийн логигоор сайжруулсан түлш шаардлага хангахгүй юм байна л гэсэн үг. Тэгээд энэ үйлдвэрийг яг хэдэн төгрөгөөр барьсан юм бэ, яагаад ийм их хэмжээний өр үүссэн юм бэ гэдэг асуулга дээр огт хариулаагүй. Эрчим хүчний яам хот мэднэ гэдэг ерөнхий хариулт өгдөг болсон. Монгол Улс нэг Засгийн газартай нэгдсэн улс. Яахаараа ингээд хариуцаж байгаа яамнууд нь хот мэднэ гэдэг болсон юм. Хот гэж тусдаа Засгийн газар бий болсон юм уу? Хот шийднэ, хот мэднэ гэдэг хариулт өгсөн.

Хоёрт, өнгөрсөн жилийн сонсгол дээр ДЭМБ агаар орчны энэ сайжруулсан түлш, коксожсон түлшийг түлээд дотоод орчны бохирдол нь хүний эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлж байгаа юм бэ гэдэг судалгааг хийгээд дууссан. Энэ дүгнэлтийг яагаад нуугаад байгаа юм? Энэ дүгнэлтийг хэзээ ил болгох юм бэ? Энэ дүгнэлт гарсан байгаа шүү. Иргэдэд байгаа эргэлзээг нэг тайлмаар байна. Бидний энэ хэрэглээд байгаа та бүхний энэ лоббигоор БНХАУ-аас 226 тэрбум төгрөгөөр авч

байгаа энэ коксон түлш чинь дотоод орчны агаарын бохирдолд түлээд эхлэхээр, галд шатаад эхлэхээр ямар нөлөөлөл үзүүлж байгаа юм бэ гэдэг ямар ч судалгаа байхгүй. Надад ирж байгаа судалгаа бол энэ нүүрс мөн үү л гэдэг судалгаа. Нүүрс юм чинь нүүрс л гээд л гарна шүү дээ. Энэ нүүрсийг шатаахад дэгдэж байгаа хий нь, үнэр нь хүний эрүүл мэндэд яаж нөлөөлж байгаа юм бэ гэдгийг судлаад иргэддээ нэг танилцуулаач гэдэг ийм хүсэлт ихээр ирж байна л даа.

Гуравт, энэ Монгол Улс нүүрсний асар их баялагтай атлаа өөрсдийн коксожсон түлшийг 1 тонныг нь 175 мянган төгрөгөөр борлуулдаг атлаа буцаагаад 1 тонныг нь 1 сая 130 мянган төгрөгөөр авч байна. Яагаад бид нар дотоодод байгаа нөөц бололцоогоо ашиглахгүй өндөр үнээр хагас коксожсон түлшийг худалдаж авах ийм шийдвэр гаргасан юм бэ? Энэний чинь үр дүн өнөөдөр.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт. Гараа өргөөрэй. Хэдэн номер вэ? 4 номер. Өөрийгөө танилцуулаарай. 6 номер.

А.Амартүвшин: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Сайжруулсан түлшний үйлдвэрийн гарсан зар яагаад хаагдсан, ямар үйл ажиллагаатай явж байгаа талаар “Тавантолгой түлш”-ийн захирал миний дараа хариулаад явчихна.

Олон улсын байгууллагуудын судалгаа өнгөрсөн утааны сонсголын үеэр гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлээд явж байгаа. Яг одоо бид нар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтраад тухайн айл өрхийн дотно болон гадна агаар орчны бохирдлын хэмжилтийг хийгээд эд дундаа ороод явж байна. Өмнө 9, 10, 11 сард айл өрхүүдэд бид нар сайжруулсан хагас кокс барьцалдуулагчгүй мидлинийг айл өрхөд 3 сонголтоор олгож эхэлсэн. 12 сараас хоёр 7 хоногийн өмнөөс эхлээд бүрэн кокс руу орсон байгаа.

Ингэснээр НҮБ-ын Хүүхдийн сан бүрэн судалгаа дээрээ энэ 3 түнш дээрээ хийгдээд явж байгаа. Эхний дүгнэлтийг 12 сарын 10-наас 15-ны хооронд танилцуулна гэсэн урьдчилсан байдлаар бид нарт мэдэгдсэн байгаа. Энэ дээр бид нар хамтраад явж байгаа.

Дэлхийн банктай бид нар эдийн засгийнх нь үр ашгийн талаар судалгаа хийчихсэн явж байгаа. Тухайн айл нь газ руу, хагас кокс руу, сэргээгдэх эрчим хүч рүү шилжсэнээс тухайн айл өрхийн эдийн засгийнх нь хувьд нь ямар эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх нь вэ гэдэг судалгааг хийгээд явж байгаа. КОЙКА-той бид нар хамтраад энэ газан шилжилтийн үед эрх зүйн хувьд ямар ямар өөрчлөлтүүдийг оруулах ёстой вэ, ямар стандартуудыг хэрхэн шийдвэрлэх ёстой вэ, эрх зүйн хувьд ямар акт хуулиуд орох ёстой вэ гэдэг дээр Солонгосын КОЙКА-той хамтраад явж байгаа.

Яагаад кокс гаднаас аваад худалдаад байгаа гэдэг асуултад хариулъя. Манай Монгол Улсад яг одоогийн байдлаар Улаанбаатар хотыг хангах коксын үйлдвэр байхгүй. Коксожсон нүүрсийг бид нар оруулж ирээд тухайн юугаараа коксожсон үйлдвэр байхгүй учраас тухайн нүүрсийг оруулж ирээд агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаад явж байгаа.

10 сард та бүхэн бас бас сонссон байх 10 сард урьдчилсан дүнгээр хүхрийн хий 40 хувиар, нөгөө нэг яригдаад байдаг тоос, тоосонцор буюу PM10 нь 18 хувиар, PM2.5 нь 9 хувиар буурсан үзүүлэлт гарсан байгаа. 11 сар дээр

харьцуулахад хүхрийн хий 39 хувь РМ10 нь 23 хувь, РМ2.5 нь 7 хувиар буурсан. Эдгээр сарууд бид нар өмнө нь сайжруулсан нүүрс, коксожсон нүүрс, барьцалдуулагчгүй мидлингээ 3 нүүрсийг хамтад нь хэрэглэж байсан үед гарсан эерэг үзүүлэлтүүд байгаа.

12 сард яг цэвэр хагас коксыг хэрэглэснээр ямар үзүүлэлтүүд, ямар эерэг агаарын чанарт эерэг үзүүлэлтүүд үзүүлж байна, аль тал дээрээ эерэг, сөрөг үзүүлэлт байна гээд гарч байна гэдэг судалгааг гараад явна. Хагас коксжуулсан.../минут дуусав./

Р.Сэддорж: Нэмж 1 минут үргэлжлүүлээд ярьчихъя.

А.Амартүвшин: Хагас коксын үйлдвэрийг барих ТЭЗҮ нь одоо 95 хувьтай Эрдэс Монгол дээр дэгдээд явж байгаа. Энэ сардаа багтаад дуусна гэсэн хариуг Эрдэс Монголоос өгсөн. Эрдэс Монгол дээр ТЭЗҮ нь дуусагдсаны дараагаар Засгийн газрын хурлаар ороод нийслэл энийг хэрэгжүүлэх үү, Эрдэс Монгол нь ТЭЗҮ-гээ хэрэглэснээрээ хагас коксын үйлдвэрээ цааш нь хэрэгжүүлэхээр бариад явах уу гэдэг шийдвэр гарна. Хэрвээ нийслэлд ирэх юм бол нийслэлийн бид нарын судалгаа аль хэдийнээ хийгээд эхэлчихсэн байгаа. 18 сарын дотор Багануурын уул уурхайг түшиглээд хагас коксын үйлдвэрийг барих боломжтой гэдэг судалгааны дүнгүүд эхнээсээ гараад ирсэн байгаа.

Ямар ч байсан хагас коксын үйлдвэрээ барьж байж бид нар хагас коксыг гаднаас импортолж оруулах гэдэг асуудлаа зогсоох.../минут дуусав./

Р.Сэддорж: 7 номер нэмж хариулна.

Ц.Эрдэнэбаяр: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Тавантолгой түлш” компанийн гүйцэтгэх захирал Эрдэнэбаяр. Баатархүү гишүүний асуултад хариулъя. Энэ 7 жилийн хугацаанд авсан нийт өр төлбөр өнөө яг одоогийн байдлаар 1.5 их наяд дээр хүрсэн байгаа. Үйлдвэрийн үндсэн хөрөнгө оруулалт бол баруун, төвийн үйлдвэр, зүүн бүсийн үйлдвэр гээд ингээд 3 үйлдвэртэй байсан. Энд үндсэн хөрөнгө оруулалт 380 тэрбум орчим. Баруун болон төвийн бүсийн үйлдвэрт салгаад ярих юм бол 120 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орсон. Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэхдээ Баруун үйлдвэрээс эхэлсэн. Өртөг, зардал багатай, маш ихтэй, бүтээмж багатай маш олон шугамууд ажилладаг байсан. “Тавантолгой түлш” компанид одоо нийтдээ ерөнхийдөө 20 үйлдвэрлэлийн шугам ажилладаг байснаас үе шаттайгаар бууруулж, үйлдвэрлэлийн.../минут дуусав./

Р.Сэддорж: 1 минут 7 номер.

Ц.Эрдэнэбаяр: Шинэчлэлийг үйлдвэрийн бүтээмжийг өсгөснөөр одоогоор 3 шугамтай ажиллаж байгаа. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй байна гэдэг Үндэсний орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2024 оны тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 21 оны 9 дүгээр тэмдэглэлээр энэ үйлдвэрийг хаах нь зүйтэй байна гэсэн ийм шийдвэрийн дагуу баруун болон төвийн үйлдвэрийг хаасан. Олон шугамтай ажиллаж байхад “Тавантолгой түлш” компанийн ажилчид 3800 дээр ажилладаг байсан. Өнөөдөр 800 хүн ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Баатархүү гишүүн дараа нь 5 минутын танд эрх байгаа юм байна. Хамгийн сүүлд нь тийм. Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Баатархүү гишүүний явуулсан асуулгад Нийслэлийн Засаг даргын хариулсан албан бичгийн хавсралт 12 дугаар сарын 1. Энэ дээр түлшний үйлдвэрлэлийн хүчин чадал, нөөц агуулахуудын бэлэн байдлыг бүрэн хангасан. Хангамжийн тасалдалгүй байдалд эрсдэл үүсгэхгүй энэ нөхцөлийг бүрдүүлсэн гэж ирүүлсэн байгаа. Худлаа энэ. Яагаад ингэж итгэлтэй хэлж байна гэхээр 11 дүгээр сарын 6-нд “Тавантолгой түлш” компани өөрийнхөө сайт дээр тендер зарласан. Шигшүүр авъя гэж, шигшүүр бүүр түрээсэлье. Улс нь хар аа энэ ингээд хүмүүсийнхээ түлшийг бэлдээд байна л даа аминдаа. Өөрсдөө шигшүүр байхгүй. Худалдаж авах гээд 2, 3 тендер зарлаад чадаагүй. Ингээд өвөлтэй золгоод сүүлдээ түрээсэлье гэдэг тендер зарлаж байсан. 11 дүгээр сарын 6-нд тендер зарласан.

Энгийн логигоор бодоход 11 сарын дунд, сүүл хүртэл шигшүүргүй байсан та нар. Шигшүүргүй байж яаж наад түлшээ үйлдвэрлэж гаргах юм, яаж хангах юм. Энэ бол бүтэн сар, бараг 20 хоног, сарын хугацаанд үйлдвэрлэлээ бүтэн явуулж чадаагүй байж байж гүйцэд ханган нийлүүлж чадахгүй. Ингээд түлш олдохгүй байна гэдэг асуудал үүссэн. Тэгсэн чинь наад талд сууж байгаа нүдний шилтэй дарга чинь ийм хэн бил лээ? Энэ 22 дээр зогсчихсон нэг портер зогсоочихсон, баахан шуудай аччихсан машин үзүүлээд энэ ингээд хотоос гаргаад байна гээд. Энэ бол залилан шүү дээ. Хууран мэхлэх ажил шүү дээ. Түлшээ та нар гүйцэд үйлдвэрлэж чадаагүй. Хангалттай хэмжээнд нөөцөө бүрдүүлж чадаагүй, түгээлтээ хангалттай хугацаанд хийж чадаагүй. 2, 3-хан хоногийн өмнө хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдөө яваад сурвалжилсан юм. Та нар явахаараа худлаа яриад байдаг учраас сурвалжилгууд бүгд хэлж байгаа юм. Түлш олдохгүй байна, хүрэлцээ муу байна. Тэгээд хотын дарга дээр очоод яг газар дээр нь ажиллахаар түлш олдохгүй байна гээд хүмүүс хэлж байна гэхээр чи хаанаас явж байгаа юм гээд ингээд мэдрэлдээд байдаг. Хүн загнаад байдаг. Энэ “Тавантолгой түлш” компанитай бүүр ноцтой хэргүүд удахгүй яригдана. Хүний амь нас хохироод шүүхээс түлшний чанараас болсон гээд шийдвэр гарчихсан байгаа шүү дээ.

Р.Сэддорж: 5 номер. 6 номер хариулна.

А.Амартүвшин: Лодойсамбуу гишүүнд гишүүний асуултад хариулъя.

Р.Сэддорж: Өөрийгөө танилцуул.

А.Амартүвшин: Нийслэлийн Засаг даргын орлогч Амартүвшин байна. 11 сарын 6-нд бид тэр шигшүүрийг авъя гэсэн тендер зарласан байгаа. Энэ нь бэлтгэлээ муу хангасандаа биш бид нар барьцалдуулагчгүй баяжуулсан, угааж баяжуулсан мийдлингийг ард иргэдэд бас өгье гэдэг шийдвэр гарсны үндсэн дээр нөгөө “Энержи ресурс”-оос ирж байгаа түлшийг шигших, тэгээд шуудайлах процедур дээр энэ шаардлагатай болоод ингээд зарласан байгаа.

Яагаад гэвэл тухайн үед сайжруулсан түлшээ ч больё, коксоо ч больё, буцаад түүхий нүүрсээ түлье гэдэг асуудал сошиал ертөнц дээр болон ард иргэдээс манай нийслэл дээр ч гэсэн маш их тийм олон хүсэлтүүд ирсэн учраас эд нар дээр нь үндэслээд бид нар энэ барьцалдуулагчгүйгээр нь энэ мидлинийг шуудайлж өгье гэдэг шийдвэрийг гаргаад явсан байгаа. Тэрийг тэгээд хэрэгжүүлээд ингээд яваад дууссан.

За окэй одоо энэ хулгайн асуудал, намайг тэр портерыг бариад явж байгаагаас тэр тэгсэн. Энэ бол байсан. Бүх нотолгоо, баримттайгаа байгаа. Яагаад гэвэл бид нар “Hotula” системийг ашиглалтад оруулсан энэ зун. Тэрийг E-Mongolia, Dan систем, ХАӨМС-тай ингээд бүгдийг нь холбоод үзэхэд нийтдээ 185 мянган карт байна. Өнгөрсөн жил бид нар 172 мянган айл өрх нүүрс түлж байгаа мөртөө 285 мянган картыг ашиглаж нүүрс авч байна. Үүн дотроос би бас хэвлэлийнхэнд хэлж байсан. 7200 нас барчихсан иргэний картыг өнөөдөр Hotula-г холбох хүртэл карт аваад явж байсан.

Цэгүүд дээр нүүрс дуусаад байна гэдэг. Энэ дээр бид нар хяналт шалгалтыг хийсэн. Камер дээр ч бичлэгүүд бүгд байгаа. 10 тонны нүүрс буунгуут 2 Маяти орж ирээд 60-70 карт гаргаж ирж 2-хон секундийн зайтайгаар бүгдийг нь уншуулаад нөгөө буусан нүүрсийг чинь 2 Маяти дээр ачаад л аваад явчхаж байгаа. Эд нар нь бид нар нь араас нь дагаж яваад бичлэг хийгээд аль нь гадагшаа гарч байна гээд л энэ бүх баримттайгаа байгаа. Цагдаа дээр ч, экологийн цагдаа дээр ч энэ ингээд хянагдаад явж байгаа. Энэ системээ ингэж холбосноор нийтдээ яг Улаанбаатар хотод 152 мянган айл өрх нүүрс худалдан авч байна. Энийг ингээд цэгцэлсэн. 285 мянган картаас 152 мянга яасан. Өөрөөр хэлэх юм бол өнгөрсөн жил бид нар 450 мянган тонн нүүрсийг түлж өвлийг давсан.

Энэ жил бид нар энэ ажлыг хийснээс урьдаар бид нар 330-340 тонныг л түлж энэ өвлийг давна гэсэн тооцоололтой явж байгаа.

Р.Сэддорж: Лодойсамбуу гишүүн тодруулж асууна.

Ч.Лодойсамбуу: Бэлтгэл ажлаа хангаагүй гэдгээ өөрсдөө амаараа хэллээ. Нэгт.

Хоёрт, зах зээл ингэж ажилладаг юм. Эрэлт нь их байвал нийлүүлэлтээр өрсөлдөөн бий болдог байхгүй юу. Одоо сая та гэнэт бөөнөөр нь ачаад явж байгаа хүмүүсийг буруутгах гээд байна шүү дээ. Наадах чинь нөгөө талдаа эрэлт нь гахчихаад байгаа байхгүй юу даа. Зохион байгуулж чадахгүй байгаа учраас тэн дундуур чинь хүмүүс ороод байна шүү дээ. Тэр орж байгаа хүмүүсийн буруу биш зохион байгуулалтын буруу. Эрэлтээ бид нар анзаарахгүй байна. Энэ ер нь цогцоороо буруу шүү дээ. Жишээлбэл төрөөс яг манай үйлдвэрлэсэн, төрийн үйлдвэрлэсэн түлшийг түл, энийг л түл. Ямар ч сонголт байхгүй, зах зээл энд ажилладаггүй, дарга нар нь зах зээлийг ойлгодоггүй, бүүр үзэн яддаг, өрсөлдөөнийг үзэн яддаг, хүн ашиг олохоор боож үхэх шахдаг ийм дарга нартай. Тэгээд тэр хүмүүстээ буруу өгөөд өөрсдийнхөө ажлын зохион байгуулалтыг өмөөрөөд суугаад байдаг.

Р.Сэддорж: Хариулт байна уу? Товч, тодорхой хариулаарай. 6 номер. Цэнгүүн гишүүнийг нэмье.

А.Амартүвшин: Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя. Энэ чинь өөрөө нөгөө төрөөс бид нар нөгөө татаастай олгож байгаа нүүрс гишүүн ээ. Нийт яг үйлдвэрээсээ яг зах зээлийнх нь юунд нь гарах юм бол 1 шуудай 25 кг-тай нүүрс маань 25-28 мянган төгрөгийн үнэтэй борлуулагдах гээд байгаа. Татаас нь ороод бид тэр чинь 3750 төгрөгөөр айл өрхүүдээр борлуулагдаж байгаа. Мөн Үндэсний хорооны шийдвэрээр бид нар хагас коксыг 5 мянган төгрөгөөр явж байгаа.

Өнгөрсөн жилүүдэд зөвхөн энэ таны энэ хөндөж байгаа асуудал бас зөв л дөө. Өнгөрсөн жилүүдэд зөвхөн бид нар энэ татаасанд 1.4 их наяд төгрөгийг гаргасан. Таны ярьж байгаа бол, тийм нийт юугаар нийт сайжруулсан түлшийг хэрэглэж эхэлснээс хойш гэсэн үг байгаа. Тийм байгаа. Нүүрсний цэгүүдийн хангамжийн асуудлаар гэх юм бол.../минут дуусав./

Р.Сэддорж: Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Энэ одоо тэгээд хэцүү л дээ. Тануусын гаргаж байгаа энэ шийдвэрүүд бүүр ийм байнгын л хэлж байгаа. Ямар ч тийм шинжлэх ухаан суурьгүй, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлж алхаагүй, энэ балай дандаа нэг юм шатаая гэсэн. Тэгээд тэр дундуур нь мөнгө идэх гэсэн нэг ийм л юм явж байгаа шүү дээ. Амартүвшин дарга би танд урьд нь хэлж байсан тээ? Одоо жоохон технологи суурьтай ажиллах хэрэгтэй. Энэ “Тавантолгойн түлш” яагаад дампуурсан юм? Өөрөө өөртөө зориулж стандарт тануус батлаад л тэгээд л дампуурчихсан шүү дээ. Одоо харж байгаарай. Энэ жил түрүүний Амартүвшин дарга таны хэлж байгаа PM10, PM2.5 чинь одоо харагдаж байгаа гоё юм шиг харагдана за юу. Дараа жил энэ чинь хүндрээд эхэлнэ шүү. Шахмал түлш нь энэ “Тавантолгой түлш” чинь яг ийм байсан шүү дээ. Анхны жил па пу бүгд гоё байна гээд л тэгсэн тийм биз дээ. Тэгээд л дараагийн жилээсээ тэгээд л дуусна. Энэ бол шийдэл биш.

Дээрээс нь утааны сонсгол хийгээд улсын төсвөөс мөнгө үрэхгүй гэсэн. Гэтэл та нар яалаа луйвардаад “Эрдэнэс Монгол”-оос, “Эрдэнэс Тавантолгой”-гоос мөнгийг нь гаргуулчихсан. Энэ чинь компани шүү дээ төрийн мөнгө биш гэхихсэн. Яг энэнтэй холбоотой ТӨК-уд улсын төсөвтэй адилхан хэмжээний тэрнээс давсан хэмжээний мөнгийг захиран зарцуулж байгаа. Энийг бас Улсын Их Хурлын гишүүд бид нар хянаж чадахгүй байгаа шүү. Тэгэхээр энийг түрүүн бас энэ Амартүвшин дарга бас баталчихлаа шүү дээ.

Тэгэхээр яаж шийдэх вэ? Дэлхий цаашаа яаж хөгжөөд байгаа юм? Сэргээгдэх шүү дээ. Ялангуяа Монголын нөхцөлд бол. Тэгээд энэ сэргээгдэх гээд энэ манай энэ бас олны танил одууд тэр Сөрөлт хэн юм билээ олон хүмүүс юм хийгээд яваад байгаа юм жүжигчин. Тэгээд тэр сэргээгдэх дээрээ бодлого байхгүй. Одоо яамныхан энд сууж байна. Түрүүн сэргээгдэх гээд л нэг юм яриад байх шиг байна. Яг үнэнийг хэлэхэд 220квт-тай 28-30м²-тай 5 ханатай гэрт амьдарч байгаа нэг өрх 5квт-ын сэргээгдэх эрчим хүчний нарны систем инвертертэй нь, батарей хураагууртай хийчхээд өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтаар хийчхээд төвийн сүлжээ рүү холбоё гэхээр асар их дарамттай байгаа шүү дээ. Инженер нь ирнэ, тэгээд л дүүрэг болно, тэгээд л баруун, зүүнээрээ хуваагдаад л ингээд л баахан ч явдал чирэгдэл болгодог. Шийдэж өгдөггүй. 380 ч гэсэн тийм байгаа шүү дээ. Холбогдох гэж аягүй удна. Тэгээд амар байгаа, хялбар байгаа гээд байдаг. Тийм юм байхгүй байгаа шүү амьдрал дээр. Энийг ил болгож та хэдэд би видео хийж оруулна за юу. Нэмэлтээ авчихъя. Нэмэлт 1 минут авчихъя.

Цаашдаа та хэд бодлогын шийдвэр гаргах гэж байгаа бол юмаа зөв хар. Яг өнөөдөр бид нарт боломж байгаа. Утаанаасаа салъя гэвэл сэргээгдэх эрчим хүч. Европын холбооны улсууд ялангуяа хаус хороололд амьдардаг хүмүүс бүгд хашаагаа нарны панелууд болгож байгаа. Дээврийг нь нарны панелууд болгоод эхэлчихсэн. Давуу тал нь юу юм? Өөрөө өөрийнхөө хэрэглээг хангачихна. Нэгд.

Хоёрт гэх юм бол төв рүү өгөөд орлого олчихно. Одоогийн манай Эрчим хүчний тухай хууль болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар энэ нь нээлттэй байгаа. Иргэн 20квт хүртэл үйлдвэрлэж болно гэж байгаа. Тэрийгээ төв рүү нийлүүлээд буцаагаад мөнгөө авч чаддаггүй. Энийгээ нээж өг л дөө. Сар болгон тэр хэдэн киловаттыг нийлүүлсэн юм тэрүүгээр нь мөнгийг нь буцааж өг л дөө иргэдэд. Авч чадахгүй байгаа төрөөс авлагатай 4, 5 сая, 5, 6, 7, 8 сая саяын авлагатай баахан өрх байдаг. Тэгээд яах вэ гэхээр дүйцүүлчихнэ гэдэг. Өвөл болно шүү дээ. Төвөөс та нэг буцаагаад авахаар чинь бид нар дүйцүүлчихнэ.

Үгүй тэгвэл тэр хүний үйлдвэрлэл хийгээд өгсөн мөнгөнд нь тануус хүүг бодож өг л дөө. Үгүй тэгээд ингээд ийм бодлогын юм руугаа ороод тэр иргэндээ ч хэрэгтэй, төрд ч хэрэгтэй, улсын төсөв дээр ч дарамт болдоггүй, тодорхой хугацаанд 5, 10 жилийн дараа эрчим хүчнийхээ төлбөрийг төлж байгаа юм шигээр төлөөд өөрөө хөрөнгөтэй болчихно тэр хүмүүс. Энэ рүүгээ ороод өгөөч гэж зөндөө хэлээд ямар ч шийдэл байхгүй, нүүрсээ түлье, шатааа гээд л байж байна. Тэгээд ийм байдлаа бас зогсоомоор байгаад байна. Энэ дээр ямар.../минут дуусав./

Р.Сэддорж: 5 номер.

Б.Ерэн-Өлзий: Хэрэглэгчийн түвшинд хэрэглэгч өөрөө барьсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс сүлжээнд нийлүүлэхтэй холбоотой журмыг аль болохоор дарамтгүй, хүнд сурталгүй болгох талд нь бид нар анхаарч ажиллаж байгаа. Энэ журам 2020 онд батлагдсан. 24 онд бид нар шинэчилсэн. Одоо ахиад бас яаж хөнгөлөх вэ гэдэг аль болохоор хэрэглэгчдэд дарамтгүй байлгах вэ гэдэг дээр бид нар бас ахиад ярилцаад явж байгаа. Гол цаад агуулга нь болохоор дэд станц талаас тухайн хороолол, гудмыг таслаад түгээх сүлжээний инженерүүд ямар нэг тасралт, гэмтэл, засвартай холбоотой ажил хийхэд аюулгүй ажиллагаатай холбоотой байдаг. Дэд станц талаас тасалсан ч гэсэн хэрэглэгчийн дээврээс тэнд 220-ийн хүчдэл холбочихсон байвал эргээд тэр хүнийг эрсдэлд оруулдаг ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр энийг яаж хангаж, яаж хэрэглэгчдэдээ хүнд сурталгүй, журмаа хүнд сурталгүй болгох вэ гэдэг дээр нь бид нар ажиллаж байгаа. Одоо бол хэрэглэгчийн тариф 212 төгрөг байна айл өрхийн. Үүнийг бид нар илүүдлээ сүлжээнд нийлүүлбэл 220-300 төгрөгөөр худалдаж авдаг болгож үнийг нь нэмэгдүүлсэн байгаа. Журмыг аль болохоор хүнд суртлыг бууруулах тал руу бид нар санаачилга гаргаж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: 6 номер.

А.Амартүвшин: Очирбат гишүүний асуултад хариулъя. Утааны сонсголын үеэр гарсан шийдвэрүүд, шинжлэх ухааны байгууллагуудтай бүрэн тантай ярьснаар хэрэгжүүлээд явж байгаа. ШУА, ШУТИС олон улсын Монголыг гэсэн Улаанбаатар хотын утааны асуудлыг шийдье гэсэн UNICEF, UNDP, КОЙКА, ЖАЙКА-тай бид нар дахиж судалгаагаа шинэчлэх гээд энэ бүх хамтын ажиллагаанууд хийгээд явж байгаа.

Технологийн хувьд энэ нүүрсийг хэрэглээд энэ нүүрс Улаанбаатар хотын агаар орчны бохирдлын шийдэл гэж нийслэлийн зүгээс ерөөсөө танилцуулаагүй. Бид нар нийслэлийн зүгээс юу яаж байгаа гэх юм бол шилжилтийн үедээ бид нар энэ хагас коксыг хэрэглэе, газ руу шилжүүлэе, 5 мянган айлын дулаалгын ажил дууссан. Одоо газ цэнэглэх 33 цэгийн бүтээн байгуулалтын ажлууд явагдаж байна.

Энэ сардаа багтаад бид нар тэр газ руу эхний айлуудаа холбоод эхэлнэ. ОХУ-аас энэ айлуудыг хангах газ хил даваад эхний ээлжид ороод ирчихсэн агуулах.../минут дуусав./

Р.Сэддорж: Даваасамбуугийн Мөнхбаатар хаа байна? Гараа өргөө. Хариулъя 8 номер.

Д.Мөнхбаатар: Амартүвшин орлогчийн асуулт дээр нэмж хариулъя. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар миний бие. Бид нар энэ жил 5 мянган айлыг газ руу шилжүүлж байгаа. Энэ төслийгөө бид нар Дэлхийн банктэй хамтраад энэ төсөл маань хэрвээ амжилттай болоод явах юм бол бид нар цаашдаа 46 мянган айл болоод өнгөрсөн 7 дугаар сард Байгаль орчны сайд болоод хотын даргын хамтарч баталсан ногоон бүс гэж бид нар тогтоосон. Тус ногоон бүс дээр 103 мянган айл өрх хамаарч байгаа. Бид нар 2028 он гэхэд энэ айл өрхүүдийг ер нь хатуу түвшний хэрэглээнээс бүрэн татгалзъя гэдэг байдлаар энэ ногоон бүсийн журмыг бид нар тогтоосон байгаа.

Мөн сэргээгдэх эрчим хүчний хувьд энэ жил UNDP-тэй хамтраад 100 айлыг өнгөрсөн жил 47 айл, энэ жил 100 айлыг бид нар сэргээгдэх эрчим хүчинд хамруулж байна. Ирэх жил бид нар ADB-тэй хамтраад 400 айлыг сэргээгдэх эрчим хүч рүү хамруулна. Гэхдээ сэргээгдэх эрчим хүч маань өндөр өртөгтэй байгаа. 3.4квт-ыг одоо үйлдвэрлэхэд нийтдээ 3800 ам.доллар шаардлагатай байдаг.../минут дуусав./

Р.Сэддорж: Очирбат гишүүн тодруулж асууна.

Г.Очирбат: Энэ харин юу шүү та хэд сэргээгдэхийг анхны хөрөнгө оруулалт өндөр гэдэг, өртөг өндөртэй гэж яриад байгаа. Наадах чинь буруу шүү. Дэлхий энэ зах зээл дээр ногоон эрчим хүч рүү ногоон эдийн засаг руу мөнгө нь бэлэн байгаа. 2024 оны 12 сарын байдлаар Монголын арилжааны банкнууд дээр 780 орчим тэрбум төгрөг хаашаа гарахаа хүлээгдээд байж байсан. Энийг зүгээр холбоод л өгчих. Иргэд рүүгээ холбоод банкнуудтай байгаад яах гэж байна гэхээр иргэн өөрөө станцтай өөрөө үйлдвэртэй болж байгаа юм. Бид нар санхүүг нь дэмжээд өгчхөж байгаа юм. Тэгээд цахилгааныхаа төлбөрийг төлж байгаа юм шигээр төлөөд 7-10 жилийн хугацаанд төлөөд дуусчхаж байгаа юм. Тэгээд өөрөө үйлдвэрлэлтэй болохлоор тэрнээс хойшоо мөнгө олох гэж байна. Одоо иргэдийнхээ кармаг сэгсрэх биш кармад нь яаж орлого оруулах вэ гэдгээ бод.

Одоо газ яриад ирэхээр л Амартүвшин дарга. Би танд хэлж байсан шүү. Монгол Улс газ байхгүй яг өнөөдрийн байдлаар хүнд байгаа шүү. Та нар газраа дахиад гадаадаас авна. Дахиад иргэдийнхээ кармаг тэмтрэх гэж байгаа шүү. Эдийн засаг нь аягүй хүнд болно шүү өрхийн чинь эдийн засаг. Наадах чинь шийдэл.../минут дуусав./

Р.Сэддорж: Пүрэвжавын Давааням хариулъя. Эрчим хүчний яамнаас ирсэн үү? Давааням байна уу алга байна уу? 5 номер. 8 номер.

Д.Мөнхбаатар: Очирбат гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Нийслэлийн агаарын орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар. Газны асуудал дээр бид нар ярихад одоогийн манай газны хэрэглээ жилд 47 мянган тонн Эл Пи Жи-г бид нар улсын хэмжээнд хэрэглэдэг. Энэний дийлэнх хувийг нь 90-ээс дээш хувийг нь автомашин дээр бид нар хэрэглэдэг. Учир нь юу вэ гэхлээр 2019

оноос хойш энэ оноог нь андуураагүй бол газны машины татварыг нэмсэн гэдэгтэй холбоотойгоор газны машинууд жилээс жилд одоо багасаж явж байгаа.

Мөн таны хэлж байгаатай санал нийлж байгаа нийслэлийн бодлого. Юу вэ гэхлээр ногоон зээлийг асуудлыг бид нар дэмжээд ногоон зээлийнхээ зарчмаар иргэдийг энэ сэргээгдэх эрчим хүч болоод бусад эрчим хүч рүү шилжүүлье гэдэг асуудал явж байгаа. Гэхдээ энэний цаана ногоон зээлийн санхүүжилт Байгаль орчны яаман дээр төсөвт тавигдаж Байгаль орчны яамнаас энэ ногоон зээлийн асуудал хөөцөлдөж явдаг. Нийслэлийн зүгээс Засгийн газрын тогтоолыг бэлдэж байна. Бид нар харилцааны банкнуудтай холбоод явж байгаа.

Сэргээгдэх эрчим хүчний хувьд бас нэг ойлголтын зөрүүг би бид нарын хийсэн судал.../минут дуусав./

Р.Сэддорж: 8 номер 1 минут.

Д.Мөнхбаатар: Бидний өнгөрсөн оны UNDP-ийн нөгөө 3.8 мянган доллараар 47 айлыг шилжүүлсэн. Энэ дээр тооцоо судалгаа хийгээд үзсэн. Яг ид оргил ачааллын үе буюу өвлийн 12, 1, 2 дугаар сар дээр сэргээгдэх эрчим хүч маань төдийлөн их хангалттай их хэмжээний эрчим хүчийг хуваалцаж чадахгүй байна гэдэг ийм тооцоо, судалгаа гарсан байгаа.

Учир нь нөгөө манай өөрийн нийслэлийн маань онцлог байгаад байгаа. Цаг уурын онцлог маань нар хожим манддаг, эрт жаргадаг гэх мэтчилэн. Тэгэхлээр энэ 3.8 сая мянган долларыг эрчим хүчинд оруулсан ч гэсэн хоол хийхдээ бусад эрчим хүчний зарцуулалт дээр ялт ч үгүй төвийн шугамаасаа эрчим хүчийг авч ингэж хуваалцаж байгаа. 3.8 маань зөвхөн халаалтыг л шийднэ гэдэг байдлаар явж байгаа.

Тэгэхлээр нөгөө талдаа бид нар яг агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр энэ эрчим хүчний сэргээгдэх эрчим хүчийг оруулъя гэхлээр ялгаа байхгүй төвийн эрчим хүчнээсээ ордог. Зуны цагт энэ тогийг бүрэн дүүрэн зараад явах боломжтой байгаа боловч олон улсын судалгаа дээрээс сэргээгдэх эрчим хүчийг бол най.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учраас Очирбат гишүүн 1 минут.

Г.Очирбат: Харин тийм. Тэгээд тэр 3.8квт-ыг гэдэг дээр л юм яриад байгаа юм. Хуулиараа 20 хүртэлх бололцоотой байгаа шүү дээ. 20 хүртэлх. Бид нар 20квт-ыг 07 га газартай байгаа иргэн 20квт тавьчих юм бол таны яриад байгаа хоолоо өөрөө хийгээд идчихнэ. Дулаанаа өөрөө шийдчихнэ. Утсаа цэнэглэх, бусад бүх эрчим хүчний эх үүсвэрээ шийдчихнэ. Ингээд шийдлээ бүтэн хараач гэж байгаа юм.

Тэгэхгүй та хэд 3.8 гэдгээрээ ингээд зөвхөн тэр нэг зээл авч байгаа юмаараа тархи чинь ингээд хайрцаглагдчихаад байна шүү дээ. Монгол Улсын эрчим хүчний тухай хууль болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль дээр 20 хүртэлх киловаттыг өрх үйлдвэрлэж болно гэххээд байгаа юм. Энэ дээр нь бодлогын дэмжлэг өгчих. Тэгэхээр яаж байна гэхээр иргэн орлого олъё гээд би хэлээд байна шүү дээ. Өөрөө 5-10-ыг нь хэрэглээд үлдсэн 10квт-аа зараад орлого олох гээд байна шүү дээ. Хэрвээ 20квт киловатт болчих юм бол өвлийн улирал чинь

хангалттай хүрчихнэ. Ингээд тооцоогоо сайн хийгээрэй. Би зүгээр ийм бодлогын дэмжлэг та хэдийг ажил хийдэг гэж ойлгоод байгаа, дэмжлэг үзүүлж хэлээд байгаа шүү Амартүвшин дарга.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд. 2019 оноос хойш 6 жилийн хугацаанд 11572 хүн угаартсан байна. Тэгээд энэ 6 жилийн хугацаанд 218 хүн харамсалтайгаар нас барсан гээд тоо нь өнөөдөр энэ тайлан дээр байна л даа. Тэгээд энд бас бүртгэгдээгүй хэдэн ч хүн угаартсаныг бид нар бас мэдэхгүй. Улаанбаатар хотын тухайд ингээд дайн дажингүй, энх тайван ийм хотод ингэж олноороо бид нар ингээд сүйдээд байж байхад энэ чинь үндэстнээр нь геноцит хийж байгаагаас ялгаагүй л үйлдэл байна шүү дээ. Бид нар эндээ бүүр ингээд дасчихсан. Энэ гол юм нь энэ түлшний асуудал байгаад байна. Түлшээ больчихъё оо гээд хотхонууд, айлууд үгүй бид нар зүгээр яршиг нүүрсээ түлчихье гээд. Тэгэхээр зөвшөөрлийг нь олгохгүй. Том дарга нар нь ийм шийдвэр гаргачихсан гээд өгөхгүй. Өнөөдөр бүүр хотхонууд, айлууд хөлдөх хэмжээндээ хүрчихсэн хүнд том оврын байгууламжууд ч гэсэн байгаа.

Энэ эрүүл мэндийн зардлаа бид нар бас тооцмоор байгаад байгаа юм. Хямдхан түлшээр бид нар иргэдээ хангаж байгаа гээд худлаа яриад байдаг. Хямдхан түлш өгөөд байгаа юм байхгүй шүү дээ. Нөгөө кармагаас нь бид нар татвар төлөгчдийнхөө мөнгөөр 300 тэрбум төгрөгийг зарцуулаад байгаа байхгүй юу түлшинд. Энэ ерөөсөө хямдхан юм байхгүй. Тэгээд иргэд нь эрүүл мэндээрээ нэг хүүхэд өвдөх, гэр бүлээрээ өвдөх, тэгээд энэ өвөлжингөө хэдэн ч удаа өвдөх юм, хэдэн сая төгрөгийг бид нар эмд зарцуулж байгаа юм.

Урт хугацаандаа бүр хэдэн сая төгрөгөөр хэмжигдэхээргүй эрүүл мэндийн зардал Монголчууд, Улаанбаатарчуудад төлж байгаа юм? Тэгээд сая энэ шилжилтийн процесс гээд тэгж байна л даа. Хятадаас коксожсон, хагас коксожсон нүүрс авч байгаа нь. Шилжилт нь дуусахаар болохоороо газ руу шилжих юм байна. Тэгж төсөөлж байгаа юм байна. 5 мянган айл дээр туршилт хийсэн гэж байна. Нийслэлийн 250 мянган айлаас яаж энэ 5 мянган айлыг сонгосон юм? Нэг айл дээр хэдэн төгрөгийн зардал гарсан юм?

Цаашаагаа энэ чинь эх үүсвэр нь ОХУ-аас авна гэж байна. Монголчууд өнөөдөр бензинээрээ хараат, эрчим хүчээрээ хараат гээд 2 хөршөөсөө ямар нэгэн байдлаар хараат биш тусгаар тогтносон улс байя гэж хичээж байхад ахиж нэг юмыг нь аваачиж өгөх хэрэг байна уу. Манай улс чинь эрчим хүчний маш их нөөцтэй орон. Өөрсдөө дотоодоосоо үйлдвэрлэе л дээ. Заавал энэ хямдхан түлш нийлүүлнэ гээд үнийг нь төрөөс барьчхаад, хувийн хэвшил орох орон зайг нь хаачхаад өөр боломж байхгүй гээд суугаад байхаа хэзээ болих юм бэ? Одоо иргэд тэнэг биш. Энэ хямд түлш нийлүүлж байгаа нь төрөөс өөр хийх гарцгүй гэдгийг, гэж боддог хүн байхгүй болчихсон. Ердөөсөө бид нар энэ боломжийг нь өгөөд зах зээлд нь жамаар нь явуулаад байсан бол иргэд тэр нэг түлшээ авах гэж 350 цэг дээр очерлоод яваад байх шаардлага байхгүй. Хувийн хэвшил хэрвээ орох боломжтой байсан бол айлуудтайгаа гэрээг нь хийгээд л тухайн айлынх нь хашаанд нь буулгаад өгч байгаа. Тэгээд тэр боломжийг нь бид нар бүгдээрээ төрийнхөн л дандаа хаасан шүү дээ.

Р.Сэддорж: Хариулт 6 номер.

А.Амартүвшин: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Газын 5 мянган айлыг ямар аргачлалаар сонгосон бэ гэх юм бол Салхины дээд хэсэг буюу байшин хороололтой хамгийн хил залгаа Гандан, Телевиз, Дэнжийн 1000 эдгээр. Баянгол, Чингэлтэй дүүргийн эдгээр хэсгийн айлуудыг ингээд сонгож 5000 айл дээр туршилт хийгээгүй, шилжилтийн үйл ажиллагаа явагдаж байгаа.

Энэ газны асуудал гэх юм бол бид нар газыг яг Улаанбаатар хотноо яг өнөөдөр 1 литр газ 3500 төгрөгөөр зарцуулагдаж байгаа. Оросын Иркутске Екатеринай компанитай нийслэл гэрээ хийгээд яг өнөөдрийн байдлаар бид нар 2400 төгрөгөөр борлуулахаар төлөвлөөд явж байна. Дахиад бид нар 46 мянган айлаа ашиглалтад газтай холбоод 50 мянган айлын газны хэрэглээ гэх юм бол дахиад бид нар энэ газных нь үнийг нь 1700, 800 руу оруулах бүрэн боломжтой.

Дараа нь нөгөө Сибирская сила 2 буюу Оросыг Хятадтай холбосон байгалийн хий ороод ирэх нөхцөлд энэ тухайн хий хүртэл ингээд шийдэгдээд явна гэсэн төлөвлөгөөтэй явж байна. Дэлхийн орон даяараа ерөнхийдөө газны хэрэглээ рүү шилжсэн. Бид нар ч гэсэн энэ газны хэрэглээ рүүгээ алхам дараатай шилжээд явах нь зүйтэй байх.

Дээрээс нь таны бас таны саналтай нэг байна. Энэ хараат гэдэг зүйл үүснэ гэж. V-цахилгаан станцын тендер шалгараад, компани нь шалгараад он гараад гүйцэтгэлийн ажил эхлээд явна. V-цахилгаан станц маань ойролцоогоор 30-40 мянган айлыг багтаах чадахуйц ингээд орон сууцын цахилгаан, дулаан гээд бүх зүйлийг хангах ийм боломжтой болно.

Цаашид бид нар ямар бодлогыг барьж явах вэ гэх юм бол эдгээр нүүрс түлж байгаа цахилгаан станцууд, мөн автомашинаас гарч байгаа энэ утааны асуудлуудыг нэг цогцоор нь шийдэхээс өөр зайлшгүй. Утаа ганцхан гэр хороолол дээр түлж байгаа энэ нүүрснээс гарч байгаа зүйл биш гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх. Ямар ч байсан одоогийн байдлаар гэр хорооллын айлууд маань нүүрсний хамгийн дээд бүтээгдэхүүн болох ахуйн хэрэглээнд хэрэглэж болохуйц хагас коксыг хэрэглээд явж байгаа.

Түүхий нүүрс түлж байгаа жилд 5.8 сая түүхий нүүрс түлж байгаа манай 5 цахилгаан станц дээрээс нь 804 мянган автомашиныг бүх энэ нүүрсэн филтеринг янданг нь байршуулах Евро-5-ыг зөвхөн хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлэх эдгээр асуудлуудыг бүгдийг нь оруулж болон уурын болон усан халаалтын зуухнууд байгаа шүү дээ. Эд нар ингээд 140 мянган тонн түүхий нүүрсийг ингээд хэрэглэж байгаа. Эдгээр асуудлуудыг цогцоор нь шийдэж байж ард нь гарна.../минут дуусав./

Р.Сэддорж: Гишүүд ч нэлээн асууж байна. Хариулт бол тийм хангалттай биш л байна даа. Та хэд ер нь гал түлж эд нар өссөн үү багадаа, гэр хороололд амьдарч байсан уу? Сая тэр Очирбат гишүүн эд нар яриад байна шүү дээ. Ерөөсөө хосолсон байдлаар дэлхий нийт шийдэж байгаа. Энэ сэргээгдэх эрчим хүчээр гадаа гэрэлтүүлгээ хийгээд, нарны нарлаг Монгол орон шүү дээ бид нар чинь тэгээд тэр хоол, цайгаа тогоороо хийгээд аль болох төвийн эрчим хүчний тэр шугам сүлжээний ачааллыг л багасгах байдлаар ингээд хамтраад шийдчихье гээд л ингээд л бүх л эрдэмтэд ярьдаг. Та бүхэн маань бас тэрийг хийхгүй л байна.

Дээрээс нь коксын үйлдвэр Монголд хамгийн том үйлдвэр Өмнөговь аймгийн Баян-Овоо сумд байгаа. Тэр үйлдвэрийг та бүхэн яагаад ашиглаагүй юм

бэ? Энийг мэдэх хүн байна уу? Тэрний хүчин чадал эд нар асар том үйлдвэр байгаа. Тухайн үеийн Уул уурхайн яам ойлгоогүй бас үйл ажиллагааг нь эд нар зогсоож байсан. Тэгээд энэ дээр судалгаа байдаг уу? Газын машины татварыг яагаад нэмсэн юм бэ? Энэ татварыг нэмснээс болж газын машин орж ирэхээ байсан юм байна. Энэ дээрээ бас хариулт хэлээч. Энэ Эрчим хүчний яам энэ хосолсон байдлаар энэ сая Очирбат гишүүний асуултад яг тийм шийдчихээр тийм гарц гаргалгаа байгаа юу? Энэ дээр хариулаадхаач. Энэ 3 дээр. 5 номер.

Б.Ерэн-Өлзий: Газ дээр яам ахуйн түвшинд биш төвлөрсөн дулаан хангамжийн системд газыг хэрхэн нэвтрүүлэх вэ гэдэг дээр илүү түлхүү ажиллаж байна. Ахуйн түвшнээсээ гэхээсээ илүү энэ төвлөрсөн дулаан хангамжийн системийн алслагдсан цэгүүдэд газар ажилладаг дулааны станцыг барина. Энэ дулааны станцууд нь голцуу халаалтын улиралд ажиллана. Ойролцоох бас нам даралтын зуухнуудыг нэмж холбох, шинээр ямар нэг утаа үйлдвэрлэж байгаа ойролцоох аж ахуйн нэгж, барилга байгууламжийг техникийн нөхцөл болгож холбох ийм боломжийг бүрдүүлэх чиглэлд нь гол анхаарлаа хандуулж ажиллаж байгаа юм.

Энэ дээр, эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд яамны хувьд гол нь газрын асуудлуудыг шийдвэрлэх асуудал гол хүндрэл байгаа. Ахуйн түвшинд бидний гол зорьж байгаа асуудлууд нь түрүүн цахилгаан халаагуураар халаахыг дэмжих, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, өөртөө ашиглах боломжийг нь дэмжих, нэмэх нь төвлөрсөн дулаан хангамжийн системд ойр байгаа барилга байгууламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн нам даралтын зуухнуудыг аль болохоор зогсоож, төвлөрсөн дулаан хангамжийн системээсээ холбох гэсэн юм. Энэ 3 чиглэлд илүү түлхүү ажил яамнаас зохион байгуулагдаж байна.

Өнгөрсөн хугацаанд гэхэд 2017 оноос эхлээд 400 гаруй халаалтын нам даралтын зуухыг зогсоож, 500 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдийн барилгыг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбосон. Энэ ажлыг бас бид нар Дэлхийн банк, Европын сэргээн босголтын банк бас улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудаар бас энэ төвлөрсөн дулаан хангамжийн захын шугам сүлжээнүүдээ өргөтгөх маягаар бас үргэлжлүүлээд явж байгаа.

Р.Сэддорж: Энэ ажлын хэсгийн гишүүдээс өөр хариулах хүн байна уу? Энэ олон хүний нэр уншсан шүү дээ би. 5 номер, 6 номер.

А.Амартүвшин: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Би хувьдаа нүүрс түлж өссөн. Налайх дүүрэгт эмээ, өвөө дээрээ нүүрс түлж өссөн. Шилний үйлдвэрийн хажуу дахь гэр хороололд өвөө, эмээтэйгээ бага насыг өнгөрөөсөн. Тэнд Налайх болон Багануурын нүүрсийг түлж бид нар байсан.

Энэ яагаад энэ үйлдвэрүүдийн асуудал энэ кокосны үйлдвэр гэх юм бол энэ дээр “Тавантолгой түлш”-ийнхэн хариулчих.

Р.Сэддорж: 7 номер.

Ц.Эрдэнэбаяр: “Тавантолгой түлш” Эрдэнэбаяр. Кокс руу шилжих болсон шалтгаан ерөнхийдөө энэ 5 жил, 6 жил хийгдэж ирсэн мидлингийн түлш барьцалдуулагч дээр ШУА-ийн Химийн хүрээлэнтэй хамтарсан судалгаа хийгээд яаж энийг сайжруулах вэ гэдэг тал дээр үр дүн гаргая гэсэн ийм судалгаа хийлгэсэн. Үр дүн олигтой гараагүй учраас бид кокс руу шилжих ийм шилжилтийг

үндэсний хорооны шийдвэрийн дагуу Эрдэмтдийн зөвлөл зөвлөсний дагуу ингээд шилжсэн.

Энэ хугацаанд Багануурын үйлдвэр технологийн паркийн хүрээнд хийгдэж байгаа “Ян Сарьдаг” коксын үйлдвэр, Бөөрөлжүүтийн төсөл энэ дотоодын аж ахуйн нэгжүүдийг бас холбогдож санал юмыг нь авсан. Тэгэхээр бэлэн болоогүй байсан Өмнөговийн Сэддорж гишүүний асуусан тэр үйлдвэр Хятадын хөрөнгө оруулалттай металлургийн бас коксын үйлдвэр байсан.

Р.Сэддорж: 1 минут 7 номер. 7 номер 1 минут.

Ц.Эрдэнэбаяр: Энэ судалгааг ерөнхийдөө бас цаг хугацаанд нь бид хийсэн. Тендерийг нээлттэй олон улсын гадаад, дотоодын аж ахуйн нэгж оролцох бүрэн боломжтойгоор бид тендерийг нээлттэй зарлаж сонгон шалгаруулалтыг хийсэн.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1.2-т заасны дагуу эрчим хүчний сайдад асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүг асуулгын хариутай холбогдуулан үг хэлэхийг урьж байна.

Асуулгатай холбогдуулан асуулт асуух боломжтой гишүүний микрофоныг нээе.

Ц.Баатархүү: Ингээд Улсын Их Хурлын гишүүдийн ер нь иргэдийн энэ асуудалд нэг тодорхой байр суурь ерөөсөө алга боллоо. Эрчим хүчний яам Улаанбаатар хотын агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр ямар ч бодлого байхгүй байгаа юм байна. Ажлаа мэдэхгүй байгаа юм байна. Асуудалд оролцох дургүй байгаа юм байна. Хүчээр ажлыг нь хийлгэж байгаа юм байна. Учир юу юм бэ гэхээр хариулт хот мэднэ гэж байгаа юм.

Өнгөрсөн энэ 15 жилийн хугацаанд Цэвэр агаар сан, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо хот хариуцсан хүртэл сайдтай болсон. Энэ хэмжээнд дарга болгон нэг агаар орчны бохирдлыг бууруулах төслийг лоббидсон. 2 удаа зуух сольсон. 2-3 удаа түлшийг сольж байна. Ингээд 5 их наядыг хийсгэлээ. 5 их наяд төгрөг гэдэг асар их мөнгө. Энэ 5 их наядаар эрчим хүчний нэг станц барьчих боломж байсан.

Ерөөсөө асуудлыг мөнгө болгож харсан. Шинжлэх ухааны шийдэл болгож хараагүй. Утаатай тэмцэнэ гэдэг улс төр биш, янданг л бууруулах асуудал, инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулах асуудал, орон сууцын үндэсний бодлогын асуудал, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх л асуудал байсан. Энэ үндсэн шийдэл рүүгээ яваагүй. Зуух солиод л байсан. Дотоод орчны агаар орчны мэдрэгч тараагаад л байсан, цахилгаан халаагуур тараагаад л байсан, түлшийг солиод л байсан. Хариуцлага гэж юм үнэхээр алга байна.

Энэ Тавантолгой компани дээр маш олон асуудал яригдана шүү. 1.5 их наядын өртэй. 1.4 их наяд төгрөгийн татаас өгсөн. 500 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт хийсэн. Технологи нь хоцрогдсон шугам аваад ирсэн. 2019 онд би нийтийн сонсгол хийж байсан. Болохгүй байна наад үйлдвэр чинь гэж. Хэн ч хариуцлага хүлээдэггүй. Ингээд татвар төлөгчдийн 3.5 их наяд төгрөг чинь

салхинд хийсчихлээ. Хариуцлагыг тооцох ёстой. Энэ мөнгийг татвар төлөгчид төлнө өө. Монгол Улс ингээд эрчим хүч, нарны, салхины, нүүрсний, эрчим хүчний нөөц байна шүү дээ. Тэгээд эрчим хүчний хараат байлгах энэ бодлого чинь яваад байна шүү дээ. Нүүрстэй атлаа 1 тонн нүүрсийг, хагас кокс нүүрсийг 175 мянгаар борлуулдаг атлаа буцаагаад 1 сая 130 мянган төгрөгөөр 1 тонн хагас кокс нүүрсийг аваад иргэдэд өгч байна шүү дээ. Зах зээлийн зарчим алга, өрсөлдөөн алга, сонголт алга. Бүгдэд нь ингээд төр оролцчихно.

Тэгэхээр хэдүүлээ ингээд нэг технологид суурилсан, яг үндсэн энэ орон сууцынхаа шийдэл рүү оролцсон энэ бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Яамнууд удирдлага, зохион байгуулалтаа алдчихлаа. “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани бүх энэ ТЭЗҮ хийдэг, мөнгө өгдөг компани боллоо. Улсын төсвөөс илүү том төсвөө эргэлдүүлдэг газар боллоо. Яамнууд ажлаа хийхээ больсон. Бид мэдэхгүй байна гэж хариулдаг болсон. Шинэ сонгогдсон Төрийн нарийн энэ ажилдаа нэлээн чармайж ажиллах хэрэгтэй.

Хамгийн сүүлд нь энэ угаарын хийд хордож байгаа, нас барсан, эндсэн хүмүүсийн чинь тоо 900 хүрчихлээ. 900 хүрчихлээ. ДЭМБ түлш шатахад эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлж байгаа юм бэ гэдэг судалгаа хийсэн. Энэ судалгааг дарчхаад байна. Бодит үнэнийг хараад иргэддээ зөв мэдээллийг өгмөөр байна. Зөв мэдээллийг өгөх хэрэгтэй. Үнэхээр иргэдийнхээ эргэлзээг тайлах хэрэгтэй шүү дээ. Шатах явцад ямар нөлөө үзүүлж байгаа юм бэ гэдгийг л иргэд асууж байгаа. Тэрнээс энэ нүүрс мөн үү биш үү гэдэг энэ шинжилгээг асуугаагүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр Байнгын хороо анхаарч, энэ ДЭМБ-ын хийсэн судалгаа одоо 12 сарын 15-нд гарах энэ 2 судалгааг иргэддээ яг зөв мэдээллийг өгөх хэрэгтэй.

Дараагийн нэг хандлагын асуудал байна. Угаартаж эндэх юм бол иргэний буруу, түлшийг ихээр нөөцлөх юм бол иргэний буруу. Үгүй ээ заавал 7 хоног болгон очиж байхаар иргэд чинь боломжоороо нөөцлөхийг хүснэ шүү дээ. Цаг хугацаагаа хэмнэхийг хүснэ шүү дээ. Тэгээд бүх юмыг иргэний буруу гэнэ. Тэгээд иргэн дээрээ дандаа туршилт хийнэ. Одоо хийх гэж байгаа туршилт чинь газрын туршилт. Хээв нэг туршилт гээд ярьж байна шүү дээ. Одоо бид нар 2 удаа түлш сольж туршлаа. Олон хүн угаартлаа. Одоо газрын туршилт хийнэ гэнэ. Шинжлэх ухаан, технологийн үндэстэй энэ ажилд ханд.../минут дуусав./

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгээс Эрчим хүчний сайдад тавьсан асуулгын хариуг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөж байна. Өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

14.06 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

